



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг аудитад хамрагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Б.Мөнх-Очир/-т даалгасугай.

5. Аудитын тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор аудитын нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Ж.Ганчимэг/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С БҮРЭНБАТ

\\10.10.10.20\Bichig_Kherag\Tushaal\2019\A.Tushaal\0429GAG1.Docx

070382

**Аудитыг
гүйцэтгэсэн:**

Гүйцэтгэлийн аудитын
газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор
Б.Мөнх-Очир

Аудитын менежер
Л.Эрдэнэчулуун

Төрийн байгууллагын
аудитын алба:

Ахлах аудитор:
Ж.Ганчимэг

Аудитор:
Д.Баатархуяг
Ц.Цолмон
Б.Мөнхтуяа

2019 оны 4 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 263755,
262451, 261805 дугаарын
утсаар харилцана уу.

**Тайланг Үндэсний
аудитын газрын
www.audit.mn веб
сайтаас үзнэ үү.**

Хаяг:
Улаанбаатар 15160,
Бага тойруу 6,
Засгийн газрын IY байр
Монгол Улс

Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгт, дүрслэл, зургийн товъёг.....	5
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн, хугацаа.....	6
Ерөнхий мэдээлэл.....	7
БҮЛЭГ 1. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД АХИЦ ГАРААГҮЙ БАЙНА	9
▪ Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу үндсэн чиглэлийн төлөвлөлт хийгдээгүй байна.....	9
▪ Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжих үндэслэл, шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоо хангалтгүй хэвээр байна.....	13
▪ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна	15
БҮЛЭГ 2. ЗАРИМ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХУЙЦ ҮР НӨЛӨӨТЭЙ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА	18
▪ Макро эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн үр дүнгээр эдийн засгийн өсөлт бий болж, үндсэн үзүүлэлт сайжирсан ч зарим зорилт, арга хэмжээний биелэлт хангагдаагүй байна.....	18
▪ Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна.....	20
▪ Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд хийгдсэн зарим, зорилт, арга хэмжээний үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.....	21
▪ Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын салбарт хэрэгжүүлсэн БСШУСЯ, ЭМЯ-ны зарим зорилт, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, үр нөлөөг тооцоогүй байна.....	23
▪ Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн байна.....	24
▪ Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, үр дүнг бодитой тайлагнах талаар өмнөх жилээс ахиц гараагүй байна.....	25
▪ Зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг зохих хугацаанд нь шийдвэрлээгүй байна.....	27
▪ Үндсэн чиглэлийн аудит Олон улсын аудитын дээд байгууллагад хэлбэрийн хувьд ижил төстэй хэрэгжиж байна.....	27
Аудитын дүгнэлт.....	29
Аудитын зөвлөмж.....	30
▪ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал.....	31
▪ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар.....	35
▪ Хавсралт.....	35



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗХХС	Зэвсэгт хүчний хөгжлийн сан
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУВС	Олон улсын валютын сан
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
МХС	Мал хамгаалах сан
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УЦС	Усан цахилгаан станц
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ЭЗСХ	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам



Хүснэгт, дүрслэл, зургийн товъёг

Хүснэгт 1	Бодлогын зорилт, арга хэмжээний хураангуй	9
Хүснэгт 2	Зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийн хураангуй	12
Хүснэгт 3	Он дамжин төлөвлөгдсөн, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний судалгаа	13
Хүснэгт 4	Монгол улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ	18
Хүснэгт 5	Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийн үнэлгээ	25
Хүснэгт 6	Хэрэгжилтийн төлөв	25
Хүснэгт 7	Зорилт, арга хэмжээний биелэлт	24
Хүснэгт 8	Санхүүжилтийн эх үүсвэрийн гүйцэтгэл	24
Хүснэгт 9	Үндсэн чиглэлийн аудитыг гүйцэтгэх олон улсын туршлага	25
Дүрслэл 1	Бодлогын уялдаа холбооны загвар	9
Дүрслэл 2	Барим бичиг боловсруулах үе шат	9
Дүрслэл 3	Монгол улсад мөрдөгдөж буй барим бичгийн зураглал	9
Дүрслэл 4	Үндсэн чиглэлийн үе шатанд оролцогч талуудын эрх, үүргийн зураглал	15
Дүрслэл 5	Эдийн засгийн өсөлт, хувиар	17
Дүрслэл 6	Ажилгүйдлийн түвшин, хувиар	17
Дүрслэл 7	Төсвийн үзүүлэлт	18



Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн, хугацаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан 2019 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд аудит хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн байдлыг дараах дэд зорилтын хүрээнд хянан үзэж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- *Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ оновчтой төлөвлөгдсөн эсэх,*
- *Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц ажлыг зохион байгуулж, гүйцэтгэл, үр нөлөөг тооцсон эсэх.*

Аудитад УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 136 зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг зэрэг 22 төсөв захирагчийг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүй, Засгийн газрын 2016 оны 249, 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлан дараах горимыг хэрэгжүүлэв.

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, Сангийн яам, ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үнэлгээний тайланг судлах, харьцуулалт хийх,*
- *Зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах*
- *Хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тайлбар, тодруулга, нэмэлт мэдээлэл, лавлагаа авах,*
- *ҮСХ-оос гаргасан Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг судлах,*
- *Цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн эх сурвалжтай тулган баталгаажуулах,*
- *Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын шалгуур, арга аргачлалтай гүйцэтгэлийн аудитын арга зүйг хослуулах.*

Гүйцэтгэлийн аудитын стандарт, журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-ийн зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгч яам, агентлаг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

Үндсэн чиглэлд батлагдсан нийт 136 зорилт, арга хэмжээнд агуулгын хувьд давхардсан тоогоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030¹-аас 97 арга хэмжээ буюу 71 хувь, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 124 арга хэмжээ буюу 91 хувь², Эдийн засгийг сэргээх хөтөлбөрөөс 19 арга хэмжээ буюу 14 хувь³, үндэсний болон төрөөс баримтлах салбарын бодлогын баримт бичгээс 17 арга хэмжээ буюу 12 хувь тус тус тусгагдаж батлагдсан байна.

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2018 онд улсын төсвийн 772.0 тэрбум, орон нутгийн төсвийн 0.6 тэрбум, тусгай сангийн 15.4 тэрбум, гадаад эх үүсвэрээс 1,541.5 тэрбум, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 482.0 тэрбум, хувийн хэвшлийн 4,145.7 тэрбум, гадаад болон хувийн хөрөнгө оруулалтын хамтарсан санхүүжилтээс 814.2 тэрбум, нийт 7,771.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэж баримт бичигт тусгасан байна.

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэлээр 4,847.9 тэрбум төгрөг буюу нийт төлөвлөсөн хөрөнгийн 62.4 хувь зарцуулагдсан байна.

ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр⁴ хэрэгжиж шинээр концессын гэрээг байгуулахыг хязгаарласнаар уул, уурхай, эрчим хүч, зам тээврийн салбарт хэрэгжүүлэх суурь, дэд бүтцийн томоохон зорилт, арга хэмжээнд төлөвлөгдсөн 3,434.4 тэрбум төгрөгийн дотоод болон гадаад эх үүсвэрийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй нь үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээ бүрэн биелэгдэхгүйд хүргэсэн байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зарим нэр бүхий зорилт, арга хэмжээг урт, дунд хугацааны бодлогын зорилтуудтай уялдуулаагүй, агуулгын хувьд зарим арга хэмжээ давхардсан, хэрэгжих хугацаа, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслээгүй, хэрэгжилтийн явцад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг дутмаг, үр дүнд суурилсан үнэлгээ болон хяналт-шинжилгээ хийхгүй байгаагаас арга хэмжээний хэрэгжилт удаашралтай, баримт бичгийн үнэ цэнэ, ач холбогдлыг бууруулж байна.

Үндсэн чиглэлийн төлөвлөлтөд урт, дунд, хугацааны бодлогын зорилтын уялдаа холбоог хангаагүй, тухайн жилд хэрэгжүүлэх боломжгүй⁵, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой, оновчтой⁶ тооцоогүй, шалгуур болон суурь үзүүлэлт тодорхойгүй, өмнөх онд төлөвлөгдсөн ч үр дүн нь гараагүй зорилт, арга хэмжээ дахин тусгагдсан зэргээс хамаарч төлөвлөлтийн явцад ахиц гарахгүй байна.

Үндсэн чиглэлийн биелэлтийг Сангийн яам 81.6 хувийн биелэлттэй гэж үзсэн бол ЗГХЭГ 75.3 хувь буюу үүнээс үр дүнтэй хэрэгжсэн 66, тодорхой үр дүнд хүрсэн 40, эрчимжүүлэх шаардлагатай 23, хэрэгжээгүй 6, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ гэж тус тус үнэлсэн байна.

¹ МУТХҮБ 2030 УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан

² ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан

³ УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан

⁴ ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр 13 дугаар хуудас, 18 дугаар заалт, Засгийн газар төсвийн бүтцийн шинэчлэлийн талаар ахиц дэвшил гаргаж байгаа ч томоохон шийдвэрлэх асуудал байна. 2015-2016 онд өмнөх Засгийн газар концессийн барих, шилжүүлэх төслүүдийн төсвийн гадуурх өр төлбөрт ойролцоогоор ДНБ-ий 5% -тай тэнцэх хөрөнгийг бүрдүүлж гаргаасан. Одоогийн Засгийн газар үүнийг хязгаарлаж, төслийн гүйцэтгэлийн цар хүрээндээ шалтгаалан тодорхой хэмжээний өр төлбөрийг тогтоохын тулд цуврал хяналт, шалгалтыг эхлүүлсэн. Засгийн газар 2018 оны сүүл гэхэд эдгээр өр төлбөрт ДНБ-ий 0.3 хувьтай тэнцэх хөрөнгийг төлж, 2019 онд ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэхийг бууруулахаар төлөвлөсөн.

⁵ Засгийн газрын 2016 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 48.1. Үндсэн чиглэлийн төсөлд тусгасан арга хэмжээ нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай байх.

⁶ 48.2.Энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдээгдэлд нийцсэн байх



ҮАГ-аас хэрэгжүүлсэн горим, арга зүйн дагуу хийсэн үнэлгээний дүнгээр нийт 136 зорилт, арга хэмжээнээс хэрэгжсэн 54, хэрэгжилт дутуу 73, хэрэгжээгүй 9 арга хэмжээ буюу “68.4” хувийн биелэлттэй байна.

Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын хувьд үндсэн чиглэлийг төлөвлөх, зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналыг хариуцах газар, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна.

ҮАГ-аас үндсэн чиглэлийн хэрэгжилтэд УИХ-ын 2011 оны 34 дүгээр тогтоолын 2 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.8 -д заасны дагуу гүйцэтгэлийн аудит хийж байгаа боловч цаг хугацааны хувьд хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, ЗГХЭГ-аас үндсэн чиглэлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлж байх хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.

Аудитын дүнд үндэслэн үндсэн чиглэлийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнаж үр дүнг үнэлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр УИХ-ын анхааралд 2 санал толилуулж, ТЕЗ нарт 2, Сангийн сайдад 1, ЗГХЭГ-т 5 нийт 8 зөвлөмж өгч байна.



БҮЛЭГ 1. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД АХИЦ ГАРААГҮЙ БАЙНА

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу үндсэн чиглэлийн төлөвлөлт хийгдээгүй байна

1.1. Үндсэн чиглэлийн төлөвлөлтийн эрх зүйн тулгуур үндэслэлийг Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Засгийн газрын нийтлэг чиг үүрэгт “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” гэж хуульчилсан байна.

1.2. Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдэл, дараа жилийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ”, мөн 8.2-т “Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан Үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 1-д “Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоон хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ” гэж Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлсон байна.

1.3. Монгол Улсад үндэсний, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн олон бодлогын баримт бичиг байгаа боловч тэдгээрийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааны болон хэрэгжилтийн явц, хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн нэгдсэн тогтолцоогүйгээс бодлогын зорилго, зорилт давхацсан, хоорондын уялдаа холбоо хангалтгүй, хэрэгжилт нь хүссэн үр дүнд хүрээгүй зэргээс хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, оролцогч талуудын эрх үүрэг, харилцан уялдааг хангах шаардлагатай болж, улмаар “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль 2015 онд батлагдсан байна.

1.4. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох журамд хөгжлийн бодлого нь тасралтгүй, харилцан уялдаатай, нэгдмэл цогц, судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх зарчимд тулгуурлан урт хугацааны хөгжлийн бодлогод дунд хугацааны, дунд хугацааны хөгжлийн бодлогод богино хугацааны бодлого үндэслэгдсэн байх⁷

⁷Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим
5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтлана: 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх; 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх; 5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх; 5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх; 5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх; 5.1.6.ил тод, нээлттэй байх; 5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх 17.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг доор дурдсан дарааллын дагуу боловсруулна: 17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх; 17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;17.1.3.бодлогын хувилбарыг доорх шалгуурын дагуу үнэлж, оновчтой хувилбарыг сонгоно: 17.1.3.а.дэлхий нийтийн болон бүс нутгийн хөгжлийн хандлага, хамтын ажиллагааг харгалзан өөрийн орны хөгжлийн онцлогийг тусгасан эсэх; 17.1.3.б.эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрт байдалд суурилан тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэх; 17.1.3.в.олон нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн эсэх; 17.1.3.г.тэгш, хүртээмжтэй байдлыг хангасан эсэх; 17.1.3.д.бодлогын үр ашиг, хэрэгжих үндэслэл бодитой эсэх. 17.1.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.17.2.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.12.1.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулна. 12.2.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна.



зохицуулалттай буюу баримт бичгийн уялдаа холбоо, түүнийг боловсруулах дарааллыг авч үзвэл дараах байдалтай байна. /Дүрслэл 1, 2-ыг харна уу/

Дүрслэл 1. Бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо



Эх сурвалж: Аудитын баг


Дүрслэл 2. Баримт бичиг боловсруулах үе шат



1.5. ҮХГ-аас

2018 онд хийсэн судалгаагаар урт болон дунд хугацааны 203 бодлогын баримт бичиг хэрэгжиж байгаагаас 162 нь уялдаа холбоогүй байна гэж дүгнэсэн байна. /Дүрслэл 3-ыг харна уу/

Дүрслэл 3. Монгол Улсад мөрдөгдөж байгаа бодлогын баримт бичиг



1.6. Дунд хугацааны бодлогын баримт бичиг болох ЗГҮАХ, төрөөс тухайн салбарт баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн зарим зорилт нь⁸ улс орны урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой бүрэн уялдахгүй байна.

1.7. Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь улс орны макро эдийн засгийн үзүүлэлт болон улсын төсөв, санхүү, өр зээлийн бодлого буюу нэгдсэн төсвийн 3 жилийн төсөөлөл бөгөөд төсөв, өр зээлийг эдийн засгийн аль салбарыг хөгжүүлэхийн тулд ямар хэмжээтэйгээр ашиглах, түүний үр өгөөжийг хэрхэн дээшлүүлэх талаарх тооцоо судалгаа хангалтгүйгээс урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх үндэслэл болж чадахгүй байна.

1.8. Урт, дунд хугацааны бодлогын зорилтыг хангахад чиглэсэн богино хугацааны баримт бичиг болох үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө нэг талаас хариуцан хэрэгжүүлэгч байгууллага төрөөс батлан гаргаж буй хөгжлийн бодлогын баримт бичгийн хэтийн зорилтод бүрэн үндэслэдэггүй, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг дунд хугацааны

⁸ Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ын баримт бичгийн "МУ-ын хөгжлийн бодлогын тогтолцоонд тулгамдаж буй асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх арга зам" судалгааны тайлангаас



төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаартай уялдуулж тооцоогүй, нөгөө талаас нэгдсэн төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэх явцад үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвтэй уялдуулахгүй байна.

1.9. Тухайлбал, УИХ-аар 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай” хуульд 2018 оны нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 2018 онд 9,623.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байтал 2017 оны 4 дүгээр сард Сангийн яаманд бусад яам, агентлагаас ирүүлсэн үндсэн чиглэлийн төсөлд нийт 13,617.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардсан 514 зорилт, арга хэмжээний санал тусгагдсан байна.

1.10. Сангийн яам “МУТХҮБ-2030”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт, бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан нийт 7,311.4 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 99 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулсан байна.

1.11. Үндсэн чиглэлийн төслийг УИХ-ын Байнгын хороо⁹, нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх явцад 37 арга хэмжээ нэмэгдэж, нийт 7,771.4 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 136 бодлогын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан¹⁰ байна.

Хүснэгт №1. Бодлогын зорилт, арга хэмжээний хураангуй

Д/д	Бодлого	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Дэд арга хэмжээний тоо
	Бүгд	18	136	200
1	Макро эдийн засгийн бодлого	1	13	13
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	5	32	62
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	3	18	34
4	Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	5	45	57
5	Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	4	28	34

Эх сурвалж: УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоол

Хүснэгт №2. Санхүүжилтийн хураангуй /тэрбум төгрөг/

д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	2018
1	Улсын төсөв	772.0
2	Орон нутгийн төсөв	0.6
3	Төр хувийн хэвшлийн түншлэл	482.0
4	Тусгай сан /ХЭДС, ЖДҮХС, ЗХХС гм/	15.4
5	Хөгжлийн банк	-
7	Хувийн хэвшил	4,145.7
8	Гадаад эх үүсвэр	1,541.5
9	Бусад*	814.2
	Нийт	7,771.4

Тайлбар*Гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн болон улсын төсвийн холимог эх үүсвэрээр санхүүжигдэхээр батлагдсан арга хэмжээний санхүүжилтийг хамруулав

1.12. Дээрх зорилт, арга хэмжээ нь холбогдох бодлогын баримт бичгийн харгалзах заалттай уялдаж байгаа ч зарим зорилт, арга хэмжээ агуулгын хувьд үндсэн зорилттойгоо нийцэхгүй байна.

1.13. Тухайлбал, хариуцан хэрэгжүүлэгч байгууллага баримт бичгийн төслийг боловсруулахдаа нөхцөл байдлын болон үр нөлөөний тооцоо судалгааг хийгээгүй, бодлогын баримт бичгийн уялдаа холбоог судлаагүй, үндсэн чиглэлийн төслийн хэлэлцүүлгийн явцад УИХ-ын гишүүдийн саналаар нэмэгдсэн доорх арга хэмжээ МУТХҮБ-2030, ЗГҮАХ-ийн бодлогын зорилтын агуулга хоорондоо уялдаагүй байна Үүнд:

- **Монгол банк:** Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний 1.6-д “Валют болон мөнгөний захын дэд бүтцийг боловсронгуй болгох арга хэмжээ авах”, 1.7-гийн “Банк, санхүүгийн салбарыг хямралд хүргэж болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлох” гэсэн зорилт нь МУТХҮБ-2030-ын 2.1-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд бус харин 2.1.6-гийн “Макро эдийн засгийн бодлогын 2 дахь зорилт буюу “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ” гэсэн зорилттой уялдахар байна.

⁹Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо

¹⁰ УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор



- Мөн 1.10-д “Бизнес эрхлэлтийн санхүүгийн зардлыг¹¹ бууруулах бодлого хэрэгжүүлэх” гэсэн зорилт нь ЗГҮАХ-ийн 3.3.24-ийн “Тэтгэврийн зөрүүг ойртуулах¹², зээлийн хүүг бууруулах бодлого баримтална” гэсэн зорилттой уялдуулаагүй, ЗГҮАХ-ийн 3.3.24-т тусгагдсан зорилт нь МУТХҮБ-2030-ын 2.1.7-д тусгагдсан “Худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн логистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ”¹³ гэсэн зорилттой агуулгын хувьд уялдаагүй түүнчлэн Монголбанк, СЗХ-ны чиг үүрэгтэй хамааралгүй байна.
- **ХНХЯ:** Зорилт, арга хэмжээний 14.5-д “Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдний эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэсэн зорилт нь ЗГҮАХ-ийн 3.3.7-ийн “Өндөр технологийн 2000 энтэрпренёр мэргэжилтнийг бэлтгэнэ” гэсэн зорилттой агуулгын хувьд нийцээгүй байна.

1.14. Үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээний хүрэх түвшний үзүүлэлт нь салбарын бодлогын тухайн зорилт, арга хэмжээний хүрэх түвшнээс зөрүүтэй байна. Тухайлбал:

- **Монгол банк:** Зорилт, арга хэмжээний 1.3-д тусгагдсан “Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах мөнгөний бодлого хэрэгжүүлэх” гэсэн арга хэмжээний “инфляцийн түвшин, оны эцэст **6.1 хувиар**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин УИХ-аас баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн “Мөнгөний бодлогын зах зээлд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2018-2020 онд жилийн **8 хувиас дээшгүй** байлгана” гэсэн тоон үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байна.

1.15. Мөн зарим зорилт, арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлт агуулгын хувьд давхцаж батлагдсан байна. Тухайлбал:

- **ХНХЯ:** Зорилт, арга хэмжээний 1.2-т “Ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн түвшнийг бууруулах” шалгуур үзүүлэлт нь “ажилгүйдлийн түвшин, хувиар, хүрэх түвшин “8 хувиас ихгүй”, 1.9-д тусгагдсан “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх” шалгуур үзүүлэлт нь “шинээр бий болгох ажлын байрны тоо, 45.0 мянга”, 14.8-д тусгагдсан “Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих” шалгуур үзүүлэлт нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо 7.0 мянга”, “Шинээр бий болох ажлын байрны тоо 10.0 мянга” гэсэн арга хэмжээнүүд нь нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшин, ажилгүйдлийг бууруулах гэсэн үндсэн агуулгаар давхцаж байна.
- **ХХААХҮЯ:** Зорилт, арга хэмжээний 3.4-т “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих” 3.5-д тусгагдсан “Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэсэн арга хэмжээ нь агуулгын хувьд ЖДҮ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох гэсэн агуулгын хувьд давхцаж байна.

Дээрх зорилт, арга хэмжээ нь агуулгын хувьд бизнес эрхлэлтийг дэмжсэн, ажлын байрыг нэмэгдүүлэн улмаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэж байгаа ч ажилгүйдлийн түвшнийг тооцохдоо ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалт, бий болгосон ажлын байрны тоо зэргээр тооцож байгаа нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл ЖДҮХС, ХЭДС, МХС зэрэг Засгийн газрын тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд зээл олгож ажлын байрыг бий болгож байгаа ч тэдгээрийн үр дүнг нэгтгэн төлөвлөх аргачлал, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

- **ТӨБЗГ, ХХААХҮЯ:** Зорилт, арга хэмжээний 3.7-д “Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх” 3.8-д “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдан авалтын бодлогыг батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдал, цагдаагийн болон бусад төрийн байгууллагад тууштай хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэсэн арга хэмжээнүүд нь төрийн худалдан авалтын бодлого гэсэн агуулгаар давхцаж байгаа бөгөөд 3.7-д туссан арга хэмжээг ТӨБЗГ хэрэгжүүлэхээр байтал ХХААХҮЯ хэрэгжүүлэхээр батлагдсан нь төлөвлөлтийн алдаа юм.

1.16. Ийнхүү ижил агуулгын арга хэмжээг баталснаас хэрэгжилтийн тайлагнал давхцаж байгаа тул цаашид арга хэмжээг төлөвлөхдөө агуулгын хувьд нэгтгэн боловсруулах шаардлагатай байна.

¹¹Бизнес эрхлэлтийн санхүүгийн зардал гэсэн ойлголтод бүх төрлийн тусгай зөвшөөрөл /барилгын зөвшөөрөл, цахилгаан, дулаанд холбогдох зэрэг техникийн нөхцөлүүд авах болон өмчөө бүртгүүлэх, эрүүл ахуй, хорио цээр, худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, баримт бүрдүүлэлт, татвар төлөлтийн үйл ажиллагаа, гэрээ хэлцэл байгуулах зэрэг / бизнес эрхлэгч олж авахад гарах зардал бөгөөд энэ нь Монгол банк, СЗХ-ны үйл ажиллагааны үндсэн зорилттой тэр бүр нягт уялдаагүй байна.

¹²Энэ зорилтыг ХНХЯ хариуцах бөгөөд Монгол банкны чиг үүрэгтэй хамааралгүй байна.

¹³Энэ зорилтыг хэрэгжүүлэх чиг үүргийг ГЕГ, ТЕГ, төрийн захиргааны төв байгууллагууд хариуцна..



1.17. Үндсэн чиглэлд тусгагдсан зарим зорилт, арга хэмжээний утга агуулга давхацсан, урт, дунд хугацааны бодлогын зорилттой уялдаагүй байгаа нь урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дунд хугацааны бодлогын төлөвлөлтгүй, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна.

1.18. Түүнчлэн нэг талаас хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, салбарын яамд асуудлыг тодорхойлохдоо Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хангалттай тооцоо судалгаанд үндэслээгүй, хэт ерөнхий байдлаар төлөвлөдөг, төлөвлөлтийг нэгтгэн боловсруулах, хянах чиг үүрэг бүхий тухайн төрийн захиргааны байгууллагын нэгж нь зорилт арга хэмжээний харилцан нөлөөллийг тооцож судалгаа, дүн шинжилгээ хийдэггүй, нөгөө талаас төлөвлөлтийг нэгтгэн хянах чиг үүрэг бүхий Сангийн яам, ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний үр нөлөө хангалтгүй байгаатай ч холбоотой байна.

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжих үндэслэл, шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоо хангалтгүй хэвээр байна

1.19. Үндсэн чиглэлд туссан арга хэмжээний 30 орчим хувь нь үйл ажиллагааны дэс дараалал, шаардагдах хөрөнгө санхүүгийн хэмжээг үндэслэлтэй тодорхой зааж өгөөгүй, зорилтот түвшин, харгалзах үзүүлэлтийг тодорхой шалгуур үзүүлэлтээр бус “ажлын явц”, үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар” гэж ерөнхий байдлаар төлөвлөгдсөн байгаа бөгөөд өмнөх оноос төдийлөн буураагүй байна.

1.20. “**Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар**” гэж төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага өөрийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөнд тусгахдаа мөн ерөнхий байдлаар буюу тухайлбал, хууль эрх зүйн орчны судалгааг гадаад оронд туршлага судлан хэрэгжүүлэх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж санал өгөх, гарын авлага боловсруулах гэж томьёолон төлөвлөж байгаа, эсвэл тухайн арга хэмжээний хүрээнд үндэсний болон дэд хөтөлбөр боловсруулан хөтөлбөрийн хэрэгжүүлэх зэрэг ажлыг хийхээр төлөвлөн томьёолж байгаа нь учир дутагдалтай байна.

1.21. Үндсэн чиглэлд туссан зарим арга хэмжээ хэдийгээр урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловч тухайн ажлын анхан шатны бэлтгэл ажил, санхүүгийн баталгаатай байдал хангагдаагүй, тухайн онд багтан хэрэгжих боломжгүй байхад зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “*тухайн онд бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх*”-ээр томьёолж төлөвлөж байгаа нь агуулга болон томьёоллын хувьд оновчгүй, хэрэгжилтийг тайлагнах, тэдгээрийг үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал:

Бэлтгэл ажил нь хангагдаагүй, тухайн онд бүрэн хэрэгжих боломжгүй зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөж, улмаар хэрэгжилт хангалгүй байна. Үүнд:

- **ЗТХЯ:** 6.7-д Говь-Алтай-Баянхонгор-Улаанбаатарын баруун чиглэлийн хатуу хучилттай авто замын “Хүйтний хөндий” дэх засварын ажлын зураг төсөл, санхүүжилтийн асуудал нь шийдэгдээгүй байхад засварын ажлыг үйл ажиллагааны хэрэгжилтээр 100 хувь гүйцэтгэх гэж төлөвлөсөн.
- **ХЗДХЯ:** 15.11-т “Орчин үеийн эрүүл ахуйн стандартад нийцсэн шүүх эмнэлгийн байрыг шинээр байгуулах” гэсэн арга хэмжээний хувьд газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсөл нь боловсрогдоогүй байхад шалгуур үзүүлэлтийг нь “100 хувь” буюу 2 барилгыг барьж ашиглалтад оруулах гэж төлөвлөсөн.
- **БСШУСЯ:** 11.3-д Нийтийн биеийн тамир спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх ажлын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт бэлэн болж баталгаажаагүй байхад магадлан итгэмжлэгдэх байгууллагын тоог 30 гэж төлөвлөсөн.

Байршлыг нь өөрчилсөн зорилт, арга хэмжээг өмнөх оны томьёоллоор дахин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Үүнд:

УУХҮЯ:

- Зорилт, арга хэмжээний 4.5-д “Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих” гэсэн арга хэмжээний үйлдвэр барих байршлыг Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Ханбогд суманд барихаар өөрчилж, 4.4-т “Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх” гэсэн арга хэмжээний “Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах” гэсэн дэд арга хэмжээ болгон тусгасан байтал өмнөх оны томьёоллоор нь хэвээр тусгасан.



Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээ төлөвлөгдөж улмаар хэрэгжих боломжгүй болсон.

Үүнд:

ЭХЯ:

- Зорилт арга хэмжээний 5.1-д “Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх” гэсэн дэд бүтцийн томоохон арга хэмжээ болох “ДЦС 3-ын хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөх ажлын явц, 10 хувь”, “Чойбалсангийн ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх ажлын явц, 20 хувь”
- 5.3-д “Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн барилгын ажлыг үргэлжлүүлэх” гэсэн арга хэмжээний дэд арга хэмжээ “Эгийн голын 315 МВт-ын УЦС, дэд бүтцийн барилгын ажлын явц” 10 хувь
- 5.4-т “Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлэх” гэсэн арга хэмжээний дэд арга хэмжээ “Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барих санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц” 100 хувь,

ХХМТГ:

- Зорилт, арга хэмжээний 12.5-д “Мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлийн энтерпренёр бэлтгэх ажлын явц” 100 хувь, 12.6-д Төрийн байгууллагуудад цахим албан хэрэг солилцооны нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлын явц 80 хувь гэх мэт арга хэмжээ батлагджээ.

1.22. Жил бүр үндсэн чиглэлд тусгагдсан боловч хүрэх түвшин, суурь болон шалгуур үзүүлэлт өөрчлөгдөөгүй, тодорхой үр дүнд хүрээгүй, зорилт, арга хэмжээг давтан төлөвлөсөн хэвээр байна Үүнд:

Хүснэгт №3. Он дамжин төлөвлөгдсөн, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний судалгаа

д/д	Зорилт, арга хэмжээний нэр	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин хувиар
2.3	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх/ХХААХҮЯ/	Отрын бүс нутгийн судалгаанд хамрагдах талбайн хэмжээ, га	35
3.2	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	40
4.3	Таван толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулах ажлын явц, /УУХҮЯ/	Хөрөнгө оруулалтын гэрээ байхгүй, хүрэх түвшин, хувиар	20
4.4	“Уул уурхай, металлургийн цогцолбор” төслийн 2 дугаар шатны барилгын ажлын явц /УУХҮЯ/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр, хүрэх түвшин, хувиар	20
4.5	“Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих”/УУХҮЯ/,	Үйл ажиллагааны хэрэгжилтээр хүрэх түвшин, хувиар	100
5.1	Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар, Чойбалсангийн ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар, ДЦС 3-ын хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөх ажлын явц, /ЭХЯ/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр хүрэх түвшин, хувиар	100,20,10
5.2	Өмнөд говийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах хүрээнд Таван толгойн цахилгаан станцыг байгуулах /ЭХЯ/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр хүрэх түвшин, хувиар	20
5.3	Эгийн голын 315 МВт-ын УЦС, дэд бүтцийн барилгын ажлын явц /ЭХЯ/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр хүрэх түвшин, хувиар	10
6.4	Бодит салбарын өсөлтийг дэмжих төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх, /ЗТХЯ/	Нийт 6 төмөр замын төсөл, арга хэмжээ	40
6.5	Хөшгийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах ажлын явц, /ЗТХЯ/	Үйл ажиллагааны хэрэгжилтээр хүрэх түвшин, хувиар	30
16.3	“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих”, үндэсний хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэх /2017, 2018/, /ШӨХТГ/	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30-аас багагүй

Эх сурвалж:Аудитын баг

1.23. Салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, гарцыг нэмэгдүүлэх тусгаж буй арга хэмжээний зорилт, санхүүжилтийн эх үүсвэр нь өөр хоорондоо болон бусад салбарын холбогдох бодлогын зорилтын хэрэгжилтэд хэрхэн нөлөө үзүүлэхийг үндсэн чиглэлийн төлөвлөлтийг хариуцаж буй албан тушаалтан тодорхойлдоггүй, тооцоо судалгаа



хангалтгүйн улмаас бодлогын хувьд давхардсан хөтөлбөр, арга хэмжээ, аян зэргийг нэг дор зохион байгуулахаар төлөвлөгдөж байна. Тухайлбал,

- ХХААХҮЯ нь малчид тариаланчдын үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн бодлогын¹⁴ хүрээнд монгол малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор мах сүүний чиглэлийн 50-иас доошгүй фермерийн аж ахуй нэгжийг МХС-ийн 2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр ЖДҮХС, МХС-гаас 74 аж ахуй нэгжид 15,1 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Энэ нь санхүүжилтийн эх үүсвэрийг бодлоготойгоо оновчтойгоор уялдуулаагүй, тооцоо судалгаагүйтэй холбоотой байна. Түүнчлэн гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр мөн л дээрх бодлогын арга хэмжээ давхар хэрэгжиж байгаа ч тэдгээрийг мөн тооцоогүй байна.
- Мөн үйлдвэржилт 21:100 болон ЖДҮ-ийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын зорилт тавин тодорхой хэмжээгээр тоног төхөөрөмжийн татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох зэргээр бодлого хэрэгжүүлж байхад БХБЯ мөн л барилгын материалын үйлдвэрлэлийн хөгжүүлэх бодлого¹⁵ хэрэгжүүлж байгаа ч эдгээр нь хоорондоо уялдаа холбоогүй байна гэх мэт
- ЖДҮХС-ийн эх үүсвэрт 2018 онд 70.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосон бөгөөд ЖДҮ-ийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газрын тусгай сан, гадаад зээлийн төсөл, хөтөлбөрүүдийн эх үүсвэр, хөрөнгө нийт 649.0 тэрбум¹⁶ төгрөг байгаа ч нэгдсэн бодлогоор оновчтой удирдаж, үр ашгийг нэмэгдүүлэх талаар хангалттай тооцоо судалгаагүй байна.

1.24. Тооцоо судалгаагүй гадаад, дотоодын санхүүжилтийн эх үүсвэртэй олон хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн бодлогын давхардал нь эргээд тухайн бодлогын хэрэгжилт сул байх, улмаар хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй болох нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлийг дагуулж байна.

1.25. Салбаруудын бодлогын арга хэмжээ давхардсан, уялдаагүй, хөрөнгө санхүүгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа нь тухайн салбарын болон салбар хоорондын төрийн захиргааны байгууллагын газар, нэгжийн уялдаа холбоогүй байдал, төлөвлөлтийн асуудлыг хариуцах, нэгтгэх боловсон хүчний нөөц, мэдлэг чадвар, ажлын зохион байгуулалт дутмаг байгаагийн зэрэгцээ хянаж, нэгтгэх чиг үүрэг бүхий Сангийн яам, ЗГХЭГ өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар нэгдсэн арга хэмжээ аваагүй, хүлээгдэж буй үр дүнг бодитой тооцоогүйтэй холбоотой байна.

1.26. Аливаа урт, дунд хугацааны зорилгод хүрэхийн тулд үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээний харилцан нөлөөллийг тооцон тодорхойлж, санхүүжилтийн бүх эх үүсвэрийг авч үзэж хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг ашиглан асуудлыг шийдвэрлэх нь зохимжтой байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна

1.27. Манай улс 2000 оноос эхлэн Сангийн яамыг Санхүү, эдийн засгийн яам болгон өөрчилж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг бүхлээр нь тухайн яамны нэг хэлтэст хариуцуулж байснаа 2008 онд бие даасан Үндэсний хөгжил, шинэчлэлтийн хороог байгуулсан боловч эрх мэдлийн хувьд Ерөнхий сайдын дэргэдэх агентлагийн статустай байсан нь яамдыг удирдан улсын хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийхэд хүндрэл учирч 2012 оны сонгуулийн дараа татан буулган Эдийн засгийн хөгжлийн яам, Аж үйлдвэрийн яамыг байгуулан хөгжлийн бодлого, төлөвлөлтийг давхар хариуцуулж, мөн Сангийн яам голлон зангидаж байв.

¹⁴Малчид тариаланчид, ЖДҮ-ийн үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн бодлогыг салбарын 10 гаруй үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд ЖДҮХС, МХС, ТЭДС зэрэг тусгай сан, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийн санхүүжилтийн эх үүсвэрээс төрөл бүрийн хөнгөлөлттэй зээл, урамшуулал олгох хэлбэрээр хэрэгжүүлж байгаа.

¹⁵БХБЯ-ны сүүлийн 10 гаран жилийн барилгын материалын үйлдвэрийг дэмжих бодлогын үр дүнд 2018 оны байдлаар 700 гаруй барилгын үйлдвэрүүдтэй болж 45 гол нэр төрлийн бүтээгдэхүүний 70-аад хувийг дотооддоо үйлдвэрлэх хүчин чадал тавигдсан ч дийлэнх нь Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудад төвлөрснөөр борлуулах зах зээлийн багтаамжгүйгээс зарим үйлдвэрүүд нь ашиглалтгүй байсан тооцоо байна. Гэтэл үүнийг ХХААХҮЯ бодлогын төлөвлөгөөндөө ашиглаагүй байна


¹⁶Эх сурвалж Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлсэн үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан



1.28. Гэвч 2016 оны сонгуулийн үр дүнгээр дээрх яамдыг татан буулгаж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газар, Ерөнхий сайдын харьяа агентлаг ҮХГ-т давхар хариуцуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг дахин агентлагийн түвшинд тавьсан байна.

1.29. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт тайлагналд оролцогч талуудын эрх үүрэг дараах байдалтай байна.

Дүрслэл 4. Үндсэн чиглэлийн үе шатанд оролцогч талуудын эрх, үүргийн зураглал



Эх сурвалж: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, ҮАГ-ын Аудитын баг

1.30. Өөрөөр хэлбэл Сангийн яамны үндсэн чиг үүрэг нь улсын төсөв, санхүүгийн бодлого, төлөвлөлт, зарцуулалтын хяналт, тайлагналыг хариуцахын зэрэгцээ богино хугацааны хөгжлийн бодлого, салбар дундын зохицуулалтын асуудлыг хариуцахаар¹⁷, ҮХГ нь улсын урт хугацааны хөгжлийн бодлогын асуудлыг хариуцан бодлого тодорхойлогчид буюу яамдаас мэдээллийг нэхэн авч бодлогын уялдаа холбоонд дүн шинжилгээ хийх, хөгжлийн бодлогыг тодорхойлохоор заасан¹⁸, гэтэл хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт хийх журамд төрийн захиргааны байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааг үнэлж дүгнэх, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүргийг ЗГХЭГ хариуцахаар¹⁹ байгаа нь чиг үүргийн хувьд давхцаж байна.

1.31. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хөгжлийн бодлогын нэгдсэн байдал, уялдаа холбоог хангах гэсэн үндсэн зорилготой нийцэхгүйн дээр Сангийн яам болон ҮХГ улсын нэгдсэн бодлогын төлөвлөлтийг хэрхэн хариуцан боловсруулах тухай асуудал огт тусгагдаагүй, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай болон Засгийн газрын тухай хуулийн зохицуулалтууд нь өөр хоорондоо зөрчилтэй байна.

¹⁷Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 2-т "Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СЯ) холбогдох төрийн захиргааны төв байгууллагаатай(ТЗТБ) хамтран боловсруулна." 10.4-т "Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг СЯ холбогдох ТЗТБ-тай хамтран боловсруулна." 12.6-д "СЯ нь ТЗТБ болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг хүлээн авч нэгтгэн, УХОХ, ТХМ-уялдуулан боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор ЗГ-т хүргүүлнэ", Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 6-д Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал" тус тус хуульчлагдсан байна.

¹⁸Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22.3-т "Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ҮХГ) нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө", 22.5.ҮХГ нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ", Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг "эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал" нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд буюу Үндэсний хөгжлийн газрын хэрэгжүүлэх чиг үүрэг байхаар заажээ.

¹⁹Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлан илгээх, хүлээн авах мэдээллийн урсгалыг удирдахад ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /unelgee.mn/-г ЗГХЭГ ашиглаж байгаа ч одоогоор ашиглалтгүй байна.



1.32. Үүнээс үзэхэд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт тогтворгүй, эрх үүргийн хувьд бодлого төлөвлөлт, тайлагнал, хяналтын чиг үүрэг нь Сангийн яам, ҮХГ, ЗГХЭГ-ын дунд давхардалтай байна.

1.33. Цаашид Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцсан байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, хариуцлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон давхардлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. ЗАРИМ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХУЙЦ ҮР НӨЛӨӨТЭЙ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА

2.1. Үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж хэрэгжүүлэхийг Засгийн газар, Монголбанк, СЗХ болон холбогдох бусад хариуцан хэрэгжүүлэгч байгууллагад УИХ²⁰-аас үүрэг болгожээ.

2.2. Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага нь үндсэн чиглэлийн зорилтыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оны эхнээс тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хагас, бүтэн жилд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж сайдын болон удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн тайланг хуулийн хугацаанд Сангийн яаманд, мөн яамнаас 10 хоногийн дотор нэгтгэн, хяналт шинжилгээ, үнэлгээ хийн ЗГХЭГ-т хуулийн хугацаанд хүргүүлж хэвшсэн байна.

Макро эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн үр дүнгээр эдийн засгийн өсөлт бий болж, үндсэн үзүүлэлт сайжирсан ч зарим зорилт, арга хэмжээний биелэлт хангагдаагүй байна

2.3. Макро эдийн засгийн бодлогын хүрээнд 2018 онд эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулах, өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах, ажлын байрыг нэмэгдүүлж ажилгүйдлийн түвшинг бууруулах, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг бууруулж дунд хугацаанд эерэг болгох нөхцөлийг бүрдүүлэн эдийн засгийн суурь үзүүлэлт болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулж тогтвортой байдлыг хангах зэрэг Монголбанк, Сангийн яам, СЗХ, ХНХЯ хамтран хэрэгжүүлэх 13 зорилт, арга хэмжээнээс хэрэгжсэн 5, хэрэгжилт дутуу, эрчимжүүлэх шаардлагатай 8 арга хэмжээ байгаа бөгөөд 70.0 хувийн биелэлттэй байна.


2.4. Засгийн газар (Сангийн яам, Монголбанк) ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, өндөр хүүтэй дотоод бонд гаргахыг зогсоох, дотоод болон гадаад бондыг төлж өрийн дарамтыг бууруулах, бизнесийн зээлийн хүүгийн түвшинг бууруулж эдийн засгийг тэлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн зэрэг төсөв, мөнгөний бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 7 орчим хувьд хүрч зорилтот түвшнээс өссөн байна. /Дүрслэл 5-ийг харна уу/

Дүрслэл 5. Эдийн засгийн өсөлт, хувиар



Эх сурвалж: УСХ

Дүрслэл 6. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: УСХ


2.5. Ажилгүйдлийн түвшин буурч 6.9 хувьд хүрч зорилтот түвшнээс (8 хувь) доогуур байна. /Дүрслэл 6-г харна уу/

²⁰ УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолын 3 дахь заалт



2.6. Татварын болон экспортын орлогыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлснээр өмнөх оноос татварын орлого 1.9 их наяд төгрөгөөр, экспорт 14 хувиар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 32 хувиар өссөн, төсөв хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 11.9 тэрбум төгрөгийн ашигтай байна./Дүрслэл 7-г харна уу/

Дүрслэл 7. Төсвийн үзүүлэлт /тэрбум төгрөг/



2.7. Дээрх бодлогуудын үр нөлөөгөөр улсын зээлжих зэрэглэл өсч Фитч (Fitch Ratings), Мүүдис (Moody's Investors Service), Стандарт энд Пүүрс (S&P Global Ratings) агентлаг үнэлгээгээ В-, сөрөг" түвшнээс "В, тогтвортой" болгон нэмэгдүүлсэн байна./Хүснэгт №4-ийг харна уу/

Хүснэгт №4. Монгол улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Үзүүлэлт	Мүүдис	Фитч	Стандарт энд Пүүрс
2016	B2, сөрөг	B, тогтвортой	B+, тогтвортой
2017	Сaa1	B-, сөрөг	B-, тогтвортой
2018	B3, тогтвортой	B, тогтвортой	B, тогтвортой

Эх сурвалж: Сангийн яам

2.8. Хэдийгээр макро түвшний бодлогын үр дүнд эдийн засгийн үзүүлэлт сайжирсан ч хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын бодлогын төлөвлөлтийн алдаа, ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнд:

Монгол банк, Сангийн яам, СЗХ

- Зорилт, арга хэмжээний 1.3-т "Инфляцийн түвшнийг нам дор түвшинд барьж оны эцэст улсын хэмжээнд 8.1 хувьд хүрсэн нь зорилтот түвшин (6.1)-ээс өндөр байна.
- 1.7-д "Банк, санхүүгийн салбарыг хямралд хүргэж болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлох, шалгуур үзүүлэлт нь үйл ажиллагааны хэрэгжилтээр, хүрэх түвшин нь 100 хувь" гэсэн арга хэмжээний хувьд Монголбанк болон СЗХ-нд үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжилтийг дүгнэсэн зүйлгүй, эрсдэлийг тодорхойлох судалгааны шатанд буюу бүрэн хэрэгжээгүй.
- 1.8-д туссан "Банкны системийн зээлийн эрсдэлд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр иргэдийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах, үйл ажиллагааны хэрэгжилтээр, 100 хувь" гэсэн зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор аян зохион байгуулсан, шаардлагатай зарим журмыг шинэчлэн баталсан ч хуулийн төсөл нь байгууллагын түвшнээс дээшлээгүй зэргээс бүрэн хэрэгжээгүй.
- 1.10-д "Бизнес эрхлэлтийн санхүүгийн зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх" шалгуур үзүүлэлт нь "Мөнгөний захыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, 10 хувиар" гэсэн арга хэмжээний хувьд Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан төлөвлөгөөний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй.
- 1.11-д "Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох" гэсэн арга хэмжээний хүрээнд "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"²¹-д туссан "Үнэт цаасны зах зээлийн тухай", "Хөрөнгө оруулалтын сангийн тухай", "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн ч хэрэгжээгүй, харин олон нийтэд эрх зүйн ойлголт өгөхөөр илтгэл уралдаан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлийн мэдээлэл сурталчилгаа хийх зэрэг ажлыг зохион байгуулснаас өөрөөр хийсэн зүйлгүй байна.

Сангийн яам

- Зорилт, арга хэмжээний 1.12-т "Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулах хөтөлбөр боловсруулах, шалгуур үзүүлэлт үйл ажиллагааны хэрэгжилтээр, хүрэх түвшин 100 хувь" гэсэн арга хэмжээний хүрээнд Сангийн яам, Монголбанкны хамтарсан "Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөний төслийг боловсруулах" ажлын хэсэг улсын хэмжээнд төлөгдөх гадаад өрийн үйлчилгээний төлбөр, валютын эх үүсвэрийг судлан 2017-2018 онд төлөгдөх хуваарьтай бондуудыг²² дахин санхүүжүүлж эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан эерэг нөлөөтэй

²¹ УИХ-аас 2017 онд батлагдсан

²² Чингис, Димсам, Хөгжлийн банкны евро бондуудын төлбөрийг Гэрээг, Хуралдай бондыг арилжаалан дахин санхүүжүүлж өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.



ч “Монгол улсын гадаад өрийн хэмжээг бууруулах стратеги” нь боловсруулалтын шатанд, зээлийн үйлчилгээний төлбөр урт хугацаанд өр нэмэгдэж төсөвт ачаалал үүссэн хэвээр буюу бодлогын зорилтын шалгуур хөтөлбөр боловсрогдоогүй байна.

- 1.13-т “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх, шалгуур үзүүлэлт нь үйл ажиллагааны хэрэгжилт, 100 хувь” гэсэн арга хэмжээний хувьд төрийн байгууллагуудын зарлага нэмэгдэх ачааллыг бууруулах, хэмнэлт бий болгохоор 2017 оны төсөв, 2017 оны төсвийн тодотгол болон 2018 оны төсвийн төсөлд ТЕЗ-даас ирүүлсэн саналыг 455 тэрбум төгрөгөөр бууруулж УИХ-д өргөн мэдүүлж, 2018 оны төсвийн тухай хуулийг батлуулсан байна. Гэвч “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 13 арга хэмжээг тусган ЗГХЭГ-т 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 4-3/4784 тоотой хүргүүлсэн ч өнөөдрийг хүртэл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа буюу хөтөлбөр нь батлагдаагүй, төсвийн зарлагын хэмжээ төдийлөн буураагүй байна.

ХНХЯ

- Зорилт, арга хэмжээний 1.9-д “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэн **шинээр 45000** ажлын байр бий болгох” гэсэн зорилтын хүрээнд ХЭДС-аас 25.1 тэрбум төгрөгийг зарцуулан хүн амын онцлог бүлгийн хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрт 61573 иргэнийг хамруулж, **шинээр 27146** ажлын байр бий болгосон нь зорилтот түвшинд хүрээгүй байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна

2.9. Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын хувьд хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, хүнс, хөнгөн, ЖДҮ-ийн салбарын хөгжлийг бодлогоор дэмжих, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, зам, тээврийн бодлогын хүрээнд олон улс, орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх сайжруулах, бодит салбарын өсөлтийг дэмжих төмөр замын төслүүдийг хэрэгжүүлж логиستيкийн сүлжээг өргөжүүлэх зэрэг 5 зорилтын нийт 32 төсөл, арга хэмжээг ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ хариуцан хэрэгжүүлснээс 7 нь тодорхой үр дүнд хүрсэн, 18 нь хэрэгжилт дутуу эрчимжүүлэх шаардлагатай, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, хэрэгжээгүй 7 зорилт, арга хэмжээ байгаа бөгөөд 51.9 хувийн биелэлттэй байна.

2.10. Дээрх бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлт бусад салбартай харьцуулахад доогуур байгаа нь зарим зорилт, арга хэмжээ он дамжин төлөвлөгдсөн ч салбарын ажлын зохион байгуулалт хангалтгүй, концесс болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр тооцсон санхүүжилтийн эх үүсвэр эцэслээгүй, ТЭЗҮ гараагүй, зураг төсөл нь боловсрогдоогүй зэрэг урьдчилсан бэлтгэл хангагдаагүй, хууль шүүхийн байгууллагад олон жилийн турш маргаантай зэргээс шалтгаалжээ. Тухайлбал:

ХХААХҮЯ:

- Зорилт, арга, хэмжээний 2.3-т “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх” гэсэн арга хэмжээг 2017 онд сумын ИТХ нь дэмжээгүй байхад 2018 оны үндсэн чиглэлд дахин тусгасан ч хэрэгжээгүй,
- 3.5-д “ЖДҮ, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжилт -30 хувьд хүргэх” гэсэн нь ЖДҮХС-ийн үйл ажиллагаатай холбогдуулан хөтөлбөр батлагдаагүй гэсэн үндэслэлээр хэрэгжээгүй,
- 3.2-т “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах” гэсэн арга хэмжээний хувьд 2017-2018 онд үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулалт удааширснаас хэрэгжилт хангалтгүй,
- 2.5-д “Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах” шалгуур үзүүлэлт нь “Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, 10 га” гэсэн арга хэмжээний санхүүжилтэд хувийн хөрөнгө оруулалтаас 2.0 тэрбум төгрөг батлагдсан ч улсын төсөв, ЖДҮХС-ийн нийт 4.4 тэрбум төгрөгийг эх үүсвэрээр шийдвэрлэсэн ч талбайн хэмжээ нь 7 га буюу төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. Энэ нь төлөвлөлтийн тооцоо судалгаа хангалтгүйтэй холбоотой байна.
- 3.7-д “Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх” гэсэн арга хэмжээний тогтоолын төсөл нь санал авах шатанд байгаагаас зорилтот түвшинд хүрээгүй



УУХҮЯ

- Зорилт, арга хэмжээний 4.4-т “Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц 10 хувь” гэсэн арга хэмжээ нь хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй улмаас хэрэгжээгүй байна.

ЭХЯ

- Зорилт, арга хэмжээний 5.1-д “Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх” гэсэн арга хэмжээний дэд арга хэмжээ “Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 35 МВт-аар нэмэгдүүлэх ажлыг 100 хувь” хэрэгжүүлэхээр тооцсон ч зээлийн хэлэлцээр байгуулахад хугацаа алдсан, зураг, төсөл нь бүрэн боловсрогдож магадлалын дүгнэлт гараагүй учраас хэрэгжээгүй, мөн дэд арга хэмжээ “ДЦС 3-ын хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөх ажлын явцыг 10 хувь” гэж төлөвлөсөн ч төслийн ТЭЗҮ-ийг 2 удаа боловсруулахад төсөвт өртөө 2 дахин зөрүүтэй гарсан зэргээс хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдвэрлэх асуудал нь тодорхойгүйгээс хэрэгжээгүй, мөн дэд арга хэмжээ “Чойбалсангийн ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэх ажлыг 20 хувь” байхаар төлөвлөсөн ч санхүүжилтийн эх үүсвэр өөрчлөгдсөнөөс цаг хугацаа алдаж хэрэгжээгүй,
- 5.4-т “Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд “Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барих санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх ажлын явц /ЭХЯ/ 100 хувь” гэсэн арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүйгээс хэрэгжээгүй,
- 5.5-д Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах станцын тоог 3 аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн ч Засгийн газраас 10 аймагт зэрэг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, хүрэх үр дүн өөрчлөгдөн, санхүүжилтийн асуудал шийдвэрлэхэд хугацаа алдсанаас хэрэгжээгүй байна.

ЗТХЯ

- Зорилт арга хэмжээний 6.4-т “Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд хэрэгжих төмөр замын 6 төсөл, арга хэмжээний төмөр замын царигийн хэмжээ УИХ-аар эцэслэн тогтоогдоогүй, хөрөнгө оруулагч, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй, төслийн ТЭЗҮ-ээр үр ашиг багатай гарсан, төмөр замын трасс, хил тогтоох цэг тодорхойгүй, хууль эрх зүйн хүрээнд маргаантай асуудал байгаа зэргээс шалтгаалан хэрэгжихгүй байна.
- 6.5-д “Худалдааг хөнгөвчлөх тээвэр, логиستيкийн төв байгуулах ажлыг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд дэх “Хөшигийн хөндийн тээвэр, логиستيкийн төв байгуулах ажлын явцыг 30 хувь”-д хүргэхээр төлөвлөсөн ч он дараалан хэрэгжүүлэхээр батлагдсан Богд хан төмөр замын трассын асуудал шийдэгдээгүй, төслийн үйл ажиллагааг эхлэх боломжгүйгээс хэрэгжээгүй байна.

Хууль эрх зүйн хүрээнд маргаантай улмаас тайлант онд хэрэгжээгүй арга хэмжээний хувьд:

УУХҮЯ

- Зорилт, арга хэмжээний 4.3-т “Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд “Сентерра гоулд” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийн асуудал 2015 оноос хойш шүүхийн маргаантайгаас “Гацууртын төслийг хэрэгжүүлэх ажлын явц, 20 хувь” гэсэн арга хэмжээ хэрэгжээгүй,

ЗТХЯ

- 6.4-т тусгагдсан “Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаагаас “Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 100 хувь” гэсэн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд хийгдсэн зарим, зорилт, арга хэмжээний үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна

2.11. “Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого”-ын хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчин, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, агаар, орчны бохирдлыг бууруулах, гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлыг сайжруулах гэсэн зорилтын дагуу төлөвлөсөн нийт 18 зорилт, арга хэмжээг БХБЯ, БОАЖЯ, ОБЕГ хариуцан хэрэгжүүлснээс хэрэгжсэн буюу тодорхой үр дүнд хүрсэн 5, хэрэгжилт дутуу, эрчимжүүлэх шаардлагатай 13 зорилт, арга хэмжээ байгаа бөгөөд 65.0 хувийн биелэлттэй байна.

2.12. Уг бодлогын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнээс импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, дотоодын үйлдвэрлэл өссөн, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийн инженерийн дэд бүтцийн зарим ажил



ашиглалтад орсон зэрэг зорилтот түвшнийг хангаж байгаа эерэг үзүүлэлтүүд гарсан байна. Үүнд:

БХБЯ

- Зорилт, арга хэмжээний 7.4-д Гангийн үйлдвэрлэлийг дэмжин ажилласнаар тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн, шинээр гангийн үйлдвэр ашиглалтад орсон зэргээс дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, өмнөх онтой харьцуулахад ган туйвангийн импорт 15 хувиар буурсан,
- Дотоодын түүхий эдийг ашиглан дулаан тусгаарлах материалын үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байгаа
- Шилний үйлдвэр байгуулах төслийн ТЭЗҮ-г боловсруулж батлуулсан, түүхий эд, бүтээгдэхүүний туршилтыг хийж, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэж байгаа,
- Баян-Өлгий аймагт цементийн тээрмийн үйлдвэр баригдаж, дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэнээр тус бүс нутагт 1 тонн цементийн үнэ хямдарсан зэрэг болно.

2.13. Гэвч зарим зорилт, арга хэмжээний санхүүжилт шийдэгдээгүй, зохион байгуулалтын ажил хангалтгүй зэргээс удааширч, төлөвлөсөн үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй байна. Тухайлбал:

БХБЯ

- Зорилт, арга хэмжээний 7.1-д “Хүн амын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэсэн зорилтын хүрээнд төлөвлөгдсөн “Орон сууцны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга болон “Төрөөс нийтийн аж ахуйн салбарын талаар баримтлах бодлогын баримт бичиг”-ийн төсөл нь тус тус боловсруулагдаж тодорхой хэмжээгээр хэлэлцүүлэг хийгдсэн ч судалгааны ажил дутуугаас ХЗДХЯ, Сангийн яам, ЗГХЭГ-т хүргэгдээгүй, эцэслэн батлагдаагүй,
- 7.2-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг 100 хувь боловсруулахаар төлөвлөсөн ч бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөнд төслийг хэрэгжүүлэх нэгж, Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан төсөл боловсруулан батлуулах Үндэсний хороо, аймаг тус бүрд ажлын хэсэг байгуулагдсан зэрэг бүтэц зохион байгуулалтын ажил хийгдэж, зарим аймагт судалгааны ажил хийгдэж байгаагаас эцэслэн боловсрогдоогүй,
- 7.3-д “Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх” гэсэн арга хэмжээний дэд ажил БНХАУ-ын 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөнөөс хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэн гүйцэтгэгчийн тендер зарлагдаж, БНХАУ-ын Засгийн газраас ирүүлсэн гүйцэтгэгчээс сонгон шалгаруулалтыг явуулсан ч гэрээ байгуулагдаагүйгээс ажил эхлээгүй, 4 аймгийн цэвэрлэх байгууламжийн ажлын явцыг 70 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хөрөнгөөр Өвөрхангай аймгийн цэвэрлэх байгууламж ашиглалтад орж, Архангай, Дорноговь, Дархан, Өмнөговь аймгийн цэвэрлэх байгууламжуудын ажлыг эхлүүлсэн,
- 7.6-д “Ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд УИХ-ын ЭЗБХ-ны 35 дугаар тогтоолоор “Ипотекийн зээлийн санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай”, Засгийн газрын 369 дүгээр тогтоолоор “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ыг батлуулж, эрх зүйн орчныг сайжруулан санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн ч ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд зарим нэг халамжийн төсөл хөтөлбөрийг хязгаарлах, зогсоох заавар, чиглэл өгсний дагуу 2018 оны жилийн эцсийн байдлаар Улсын төсвөөс 118.0 тэрбум төгрөг, Ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс 191.2 тэрбум төгрөг, нийт 309.2 тэрбум төгрөгийг зээлийн санхүүжилтэд зарцуулж 4676 зээлдэгчид зээл олгосноор зорилтот түвшинд хүрээгүй.
- 7.5-д Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2018 онд хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөгдсөн УБ хотын VII, XIV хорооллын орон сууцны барилга, VII хороолол, МҮОНРТ орчмын дэд бүтэц төслийн ус, дулааны дэд бүтцийн ажил ашиглалтад орж, өмчлөгчид хүлээлгэн өгсөн ч газар чөлөөлөлтийн асуудлаас шалтгаалан зарим дэд арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй зэрэг болно.

2.14. Мөн зарим, зорилт, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээнд заасан ажлын гүйцэтгэл дутуу байхад гүйцэтгэгчид санхүүжилтийг бүрэн олгож улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Үүнд:



БОАЖЯ

- Зорилт арга хэмжээний 8.8-д тусгагдсан аялал жуулчлалын бүс нутагт түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв цогцолбор байгуулах ажлын хүрээнд “Их эзэн Чингис Хаан” түүхэн аялал жуулчлалын цогцолборын ТЭЗҮ-ийг 909.0 сая төгрөгөөр 2018 оны 11 дүгээр сарын 7-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд гүйцэтгэхээр Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК-тай, Манзушир хийдийн түүхэн дурсгалт цогцолбор, соёл, шашин, аялал жуулчлалын төв төслийн ТЭЗҮ-ийг 1,338.9 сая төгрөгөөр 2018 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэхээр “Арчер” ХХК-тай гэрээ байгуулсан байна.

Гэрээнд гүйцэтгэл тус бүрийг дүгнэсэн актыг үндэслэн төлбөрийг олгохоор заасан бөгөөд 2018 онд “Их эзэн Чингис Хаан” түүхэн аялал жуулчлалын цогцолборын ТЭЗҮ-д хийсэн ажлын гүйцэтгэлд 450.0 сая төгрөг /гэрээний дүнгийн 50.0 хувь/, Манзушир хийдийн түүхэн дурсгалт цогцолбор, соёл, шашин, аялал жуулчлалын төв болгох төслийн ТЭЗҮ-ийн ажлын гүйцэтгэлд 1,071.1 сая төгрөгийг /гэрээний дүнгийн 80.0 хувь/ тус тус олгосон байна. Гэтэл дахин гүйцэтгэл гараагүй байхад Сангийн яам гүйцэтгэгч 2 компанид гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл төлбөрийг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр тус тус олгосон нь гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгосон байна.

Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын салбарт хэрэгжүүлсэн БСШУСЯ, ЭМЯ-ны зарим зорилт, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, үр нөлөөг тооцоогүй байна

2.15. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх, соёл урлаг, спортын салбарыг төрөөс дэмжиж, үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж, эрх зүйн орчныг сайжруулах гэсэн 4 зорилтын дагуу төлөвлөсөн нийт 45 төсөл, арга хэмжээг БСШУСЯ, ЭМЯ, ХНХЯ, ХХМТГ дангаар болон хамтран хариуцаж хэрэгжүүлснээс тодорхой үр дүнд хүрч хэрэгжсэн 22, эрчимжүүлэх шаардлагатай, хэрэгжилт дутуу 21, хэрэгжээгүй 2 зорилт, арга хэмжээ байгаа бөгөөд 75.6 хувийн биелэлттэй байна.

2.16. БСШУСЯ зарим арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шалгуур үзүүлэлтэд заасан хүчин чадлыг нь багасгаж сургуулийн барилгыг худалдан авсан ч төсөвт өртөг буураагүй, үндсэн чиглэлийн гүйцэтгэлд үнэн зөв тайлагнаагүй байна. Тухайлбал:

БСШУСЯ

- Зорилт арга хэмжээний 10.2-д тусгагдсан “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн ая тухтай сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд “Баянзүрх дүүргийн 10 дугаар хороонд байршилтай 960 суудалтай сургуулийн барилга”-ыг, 4,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авахаар 2018 оны Төсвийн тухай хуулийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдаж, тухайн заасан байршилд хүчин чадлыг бууруулан 2015 онд ашиглалтад орсон 480 суудалтай 11 танхимтай сургуулийн барилгыг батлагдсан төсвийн хэмжээнд буюу 4,448.0 сая төгрөгөөр худалдан авсан байна. Үндсэн чиглэлийн биелэлтийг сургуулийн хүчин чадлыг 2 дахин багасгаж, төсөвт өртгийг бууруулаагүй худалдан авсан ч бодитой, үнэн зөв тайлагнаагүй байна.

2.17. Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлсэн “Зонхилон тохиолдох халдварт өвчний оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах”-д эм, эмийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийг эмнэлгүүдэд хуваарилсан гэх боловч ашиглалтын талаарх мэдээ, судалгааны баримт материалгүй, халдварт өвчний тархалт бодитой буурсан гэдгийг нотлох үзүүлэлт хангалтгүй байна. ҮСХ-оос гаргасан статистик мэдээнээс үзэхэд халдварт өвчнөөр өвчлөгчид 2018 онд 42.1 мянга болж, өмнөх оноос өссөн байна.

2.18. Түүнчлэн зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулах зорилтод өвлийн улиралд тархалт ихтэй амьсгалын замын халдварт томуу, томуу төст өвчнийг бууруулах талаар тусгаагүй байна. Гэтэл тайлант онд томуу, томуу төст өвчний тархалт газар авч, халдвар авсан бага насны хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ хүрэлцээгүй нөхцөл байдалтай байна. Энэ төрлийн халдварт өвчний тархалт жил бүр дэгдэлт өндөр, хүн амын



нягтрал ихтэй нийслэл хотод ихээр тохиолддог боловч ЭМЯ 2018 оны үндсэн чиглэлийн төлөвлөлтөд тусгаж, хэрэгжүүлээгүй байна.

Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн байна

2.19. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээнд эрх зүйн салбарын шинэчлэлийг үргэлжлүүлж, мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, бууруулах, төрийн өмчийн талаар баримтлах бодлогыг шинэчилж, худалдан авах ажиллагаанд дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, стандарт хэмжил зүй, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, батлан хамгаалах салбарын энхийг сахиулах, улс орны бүтээн байгуулалтыг дэмжих чадавхыг бэхжүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлж, нийт 28 арга хэмжээг ХЗДХЯ, ГХЯ, БХЯ, ТӨБЗГ, ШӨХТГ, СХЗГ, МХЕГ хариуцан хэрэгжүүлснээс тодорхой үр дүнд хүрч хэрэгжсэн 15, хэрэгжилт дутуу, эрчимжүүлэх шаардлагатай 13 зорилт, арга хэмжээ байгаа бөгөөд 82.9 хувийн биелэлттэй байна.

2.20. ХЗДХЯ-ны үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээ шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг хангаж дараах эерэг үр дүн гарсан байна. Үүнд:

ХЗДХЯ

- Улс болон орон нутгийн төсвөөс техник тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах хөрөнгө оруулалтыг хийснээр иргэний болон хуулийн этгээдийн архив, төрийн архивуудад хадгалагдаж байгаа баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн мэдээллийн санг бүрдүүлснээр төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүйгээр хүргэх нөхцөл тодорхой хэмжээгээр бүрдсэн,
- Гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн замын хяналтыг сайжруулах бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж, албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөл бололцоогоор хангасан,
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагын зөвлөмжид нийцүүлэн шинэчилсэн, үндэсний хөтөлбөр баталж, хууль эрх зүйн шинэчлэл тодорхой хэмжээгээр хийсэн,
- Ялтныг ажлын байраар хангах бодлогын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сүлжмэл, тод, модон бүтээгдэхүүн, арьсан эдлэлийн, бэлэг дурсгалын, ноос угаах, авто засварын зэрэг 6 үйлдвэрийг байгуулж, нийт хориадлын 68 хувийг ажлын байраар хангаж зорилтот түвшинд хүрсэн,
- Шүүхийн шинжилгээний албанд дижитал судлал, инженер техникийн болон гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээний лабораторийг шинээр байгуулж шүүх шинжилгээний чанарыг дээшлүүлсэн,
- Иргэдийн эрх зүйн анхан шатны мэдлэг, боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл, байдал, хэрэгцээ, шаардлагыг судлан иргэдэд эрх зүйн боловсрол, мэдлэг олгох, зайлшгүй мэдвэл зохих 15 хуулийн агуулга сурталчлах, гарын авлага боловсруулах зэргээр бүх нийтийн эрх зүйн боловсролын дээшлүүлэхэд анхаарч ажилласан зэрэг болно.

2.21. Харин бэлтгэл ажил хангагдаагүй зорилт, арга хэмжээний төлөвлөлтийн алдаа, санхүүжилтийн дутмаг байдал, үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүйгээс зарим арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Тухайлбал:

ХЗДХЯ

- Зорилт, арга хэмжээний 15.1-д “Архивын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах” гэсэн дэд арга хэмжээ, 15.2-т тусгагдсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэсэн зорилтын хүрээнд “Хууль зүйн туслалцааны тухай” болон “Гэрч хохирогчийг хамгаалах тухай” хуулийн төслүүдийн тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийсэн ч санал авахаар яамдад хүргээдсэн, сайдад танилцуулагдаж байгаа зэрэг боловсруулалтын шатанд байгаагаас эцэслэн батлагдаагүй,
- 15.8-д тусгагдсан “Хилийн заставын цахилгаан, дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шинэчлэх”, шалгуур үзүүлэлт хүрэх түвшин нь “нарны эх үүсвэрээр хангах хилийн заставын тоо 30” гэсэн арга хэмжээний санхүүжилтийг төсөв хэлэлцэх явцад тооцсон хэмжээгээр баталж өгөөгүйгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 3,206.5 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд 16 заставт 10 кВт-ын нарны станц суурилуулснаар зорилтот түвшинд хүрээгүй,



- 15.11-д тусгагдсан “Орчин үеийн эрүүл ахуйн стандартад нийцсэн шүүх эмнэлгийн байрыг шинээр байгуулах” гэсэн арга хэмжээний газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсөл нь бэлэн бус байснаас хэрэгжээгүй байна.

2.22. Батлан хамгаалах салбарын энхийг сахиулах, улс орны бүтээн байгуулалтыг дэмжих чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн зорилт арга хэмжээний хүрээнд “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсын бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг батлан эрх зүйн орчныг бүрдүүлж, ЗХХС-ийн санхүүжилтээр зэвсэгт хүчний ангийн цэргийн албан хаагчдыг МСҮТ-д сурган мэргэшүүлэх, зэвсэгт хүчний ангийн шаардлагатай барилга байгууламж, дэд бүтцийн ажлыг төлөвлөгөөний дагуу барьж ашиглалтад оруулах, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх зэргээр батлан хамгаалах салбарын чадавхыг сайжруулж байгаа ч “Монгол Улсын агаарын хил, орон зайн хяналтын системийг сайжруулж, онц чухал объект, цэргийн бүлэглэлийг агаараас халхлах боломжийг нэмэгдүүлэх” гэсэн арга хэмжээний санхүүжилт тодорхойгүй, гэрээ хэлцлийг байгуулснаас өөрөөр хийсэн зүйлгүй, дутуу хэрэгжсэн байна.

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, үр дүнг бодитой тайлагнах талаар өмнөх жилээс ахиц гараагүй байна

2.23. Үндсэн чиглэлийн биелэлтийг ихэнх хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд тухайн салбарын сайдын болон удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж, тодорхой дүгнэлт хийж, зөвлөмж өгч эхэлсэн нь өмнөх жилүүдэд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нэг талаас анхаарч ажилласан, нөгөө талаас Сангийн яам Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөж ажилласныг илтгэж байгаа нь сайшаалтай байна.

2.24. Гэвч үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хариуцан хэрэгжүүлэгч байгууллага болон Сангийн яамны хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг судлан үзэхэд зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа үнэлгээний арга зүйг ашиглан үр дүн, үр нөлөөнд тулгуурлан бодитой дүгнэхээсээ илүүтэй тухайн зорилт, арга хэмжээний нөхцөл байдлыг ихээр дурдсан, хүрсэн түвшнийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан үр дүнг бодитой дүгнээгүй, дэвшүүлсэн зорилтын гүйцэтгэлийг өөр зорилт, арга хэмжээгээр тайлагнасан зэрэг зөрчил давтагдсан нь өмнөх онуудын аудитын зөвлөмжийн мөрөөр үр дүнтэй ажил зохион байгуулаагүйтэй холбоотой бөгөөд явцын хяналт үр нөлөөгүй байгааг илтгэж байна. Иймд ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.25. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тодорхой салбарын шаардлагатай эрх зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулна гэж төлөвлөсөн ч тайлагнахдаа тухайн зорилт арга хэмжээтэй холбоотой бус тайлант онд хэрэгжсэн өөр үйл ажиллагааны биелэлтээр тайлагнасан байна. Тухайлбал:

ХХААХҮЯ

- Зорилт, арга хэмжээний 3.1-д Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд ЗГҮАХ-т туссаны дагуу Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчин, тариалангийн даатгалын эрх зүйн орчин, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон ЖДҮ, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх хөтөлбөр боловсруулахаар заасан ч тайлагнахдаа “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай”, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” зэрэг хуулиудын нэмэлт өөрчлөлт болон “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Ноолуур” хөтөлбөрүүдийг батлуулснаар тайлагнасан байна.



БОАЖЯ

- Зорилт, арга хэмжээний 8.1-д “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт, хог хаягдал орчны бохирдлыг бууруулахтай холбогдсон журам аргачлал боловсруулна гэсэн ч Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг 2018 оны 2 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд хэрэгжилт, тайлагнал зөрүүтэй байна.

2.26. Үндсэн чиглэлийн биелэлтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, гүйцэтгэлийн аудитын арга зүйг хослуулж дүгнэхэд нийт зорилт, арга хэмжээний биелэлт дунджаар 68.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №5. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийн үнэлгээ /хувиар/

№	Бодлогын хамрах хүрээ	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээний хувь					
				2018 он			2017 он		
				СЯ	ЗГХЭГ	ҮАГ	СЯ	ЗГХЭГ	ҮАГ
1	Макро эдийн засгийн бодлого	1	13	81.5	81.5	70.0	90.0	90	87.5
2	Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	5	32	70.7	62.0	51.9	72.9	66.8	59.4
3	Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	3	18	76.7	68.3	65.0	80.5	77.0	75.2
4	Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	5	45	88.0	82.2	75.6	84.2	83.4	81.1
5	Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	4	28	91.1	87.7	82.9	89.5	86.5	85.0
Дүн		18	136	81.6	76.3	68.4	83.4	80.7	77.6

Эх сурвалж: Сангийн яам, ЗГХЭГ, ҮАГ

2.27. Үндсэн чиглэлийн 2018 оны хэрэгжилтийг өмнөх онуудтай харьцуулан харуулбал,

Хүснэгт №6. Хэрэгжилтийн төлөв, /тоо, хувь/

Зорилт, арга хэмжээ	2018		2017		2016		2015	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хэрэгжсэн	54	39.8	48	40.6	55	34.8	45	49.4
Хэрэгжилт дутуу	73	53.6	66	55.9	72	45.6	35	38.4
Хэрэгжээгүй	9	6.6	4	3.5	31	19.6	11	12.2
НИЙТ	136	100	118	100	158	100	91	100

Эх сурвалж: ҮАГ-ын 2015, 2016, 2017 онд хийсэн Үндсэн чиглэлийн аудитын тайлан

2.31. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, Сангийн яам, ЗГХЭГ, ҮАГ-ын үнэлгээгээр харуулбал,

Хүснэгт №7. Зорилт арга хэмжээний биелэлт, хувиар (хариуцан хэрэгжүүлэгч байгууллагаар)

Д/д	Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	ТАХ-ний тоо	Хүрсэн түвшинд өгсөн үнэлгээ /хувиар/				Хэрэгжилт /тоогоор/		
			ТЕЗ	Сангийн яам	ЗГХЭГ	ҮАГ	Хэрэгжсэн*	Хэрэгжилт дутуу**	Хэрэгжээгүй***
1	Сангийн яам	5	88.0	88.0	88.0	76.0	3	2	-
2	ЗТХЯ	7	85.0	70.0	45.7	45.7	1	4	2



3	БОАЖЯ	8	88.8	73.8	70.0	55.0	2	6	-
4	БХЯ	5	94.0	94.0	94.0	94.0	4	1	-
5	БХБЯ	6	90.0	70.0	50.0	50.0	-	6	-
6	ГХЯ	4	85.0	77.5	77.5	77.5	2	2	-
7	ЭМЯ	9	86.0	85.0	81.3	66.3	2	7	-
8	БСШУСЯ	19	96.2	87.4	80.0	78.4	12	5	2
9	ХНХЯ	16	90.6	90.6	76.7	76.7	8	8	-
10	ХЗДХЯ	13	95.0	95.0	86.2	79.2	6	7	-
11	ЭХЯ	7	67.8	55.7	45.7	37.1	-	5	2
12	УУХҮЯ	5	82.5	70.0	70.0	44.0	1	3	1
13	ХХААХҮЯ	12	82.5	80.0	77.5	65.8	4	6	2
14	СЗХ	1	100	70.0	70.0	40.0	-	1	-
15	МХЕГ	1	100	100	100	100	1	-	-
16	СХЗГ	1	100	100	100	100	1	-	-
17	ОБЕГ	4	100	92.5	92.5	92.5	3	1	-
18	ХХМТГ	3	80.0	80.0	80.0	80.0	1	2	-
19	ҮАГ	1	70.0	70.0	40.0	70.0	-	1	-
20	ТӨБЗГ	3	100	90.0	90.0	80.0	2	1	-
21	Монгол банк	5	76.0	76.0	76.0	64.0	1	4	-
22	ШӨХТГ	1	100	70.0	70.0	70.0	-	1	-
	ДҮН	136					54	73	9

*Үр дүнтэй 90-100 хувь, **Тодорхой үр дүнд хүрсэн 60-89 хувь, ***Эрчимжүүлэх шаардлагатай 31-59 хувь

Зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг зохих хугацаанд нь шийдвэрлээгүй байна

Хүснэгт №8. Санхүүжилтийн эх үүсвэрийн гүйцэтгэл, тэрбум төгрөг

2.28. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд нийт 7,771.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр төлөвлөгдсөнөөс урьдчилсан гүйцэтгэлээр 62.4 хувь буюу 4,847.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Санхүүжилт 2018 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Улсын төсөв	772.0	1,072.2
2	Орон нутгийн төсөв	0.6	0.04
3	ТХХТ	482.0	
6	Хувийн хэвшил	4,145.7	2,836.1
7	Гадаад эх үүсвэр	1,541.5	727.1
8	Бусад	829.6	257.5
	Нийт дүн	7,771.4	4,847.9

Эх сурвалж: Сангийн яам

2.29. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 1,072.2 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 38.9 хувь буюу 300.2 тэрбум төгрөгөөр илүү байгаа нь урсгал зардалд тусгасан хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэнтэй холбоотой бөгөөд төлөвлөлтийн явцад үүнийг тогтоолд тусган баталдаггүй байна.

2.30. Харин Монгол Улс ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж шинээр концессын гэрээг хязгаарласнаар уул, уурхай, эрчим хүч, зам тээврийн салбарт хэрэгжүүлэх суурь, дэд бүтцийн томоохон зорилт, арга хэмжээнд төлөвлөгдсөн 3,434.4 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт, гадаад эх үүсвэрийн санхүүжилт хийгдээгүй нь үндсэн чиглэлийн биелэлтэд нөлөөлжээ.

Үндсэн чиглэлийн аудит Олон улсын аудитын дээд байгууллагад хэлбэрийн хувьд ижил төстэй хэрэгжиж байна

2.31. ҮАГ нь аливаа аудитыг горим стандартын дагуу хэрэгжүүлэхдээ олон улсын ижил түвшний аудитын байгууллагын аргачлал, туршлагыг судалж үздэг.

2.32. Судалгаанаас үзэхэд Австралийн Үндэсний аудитын газар нь 2013 оноос эхлэн "Үндсэн чиглэл"-ийн аудитыг Засгийн газарт аудитын үйлчилгээг үзүүлэхдээ хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Засгийн газрын бүрэлдэхүүн, түүний харьяа агентлагуудын анхаарал татсан



дутагдалтай үйл ажиллагааны нотлох баримтад үндэслэн дүгнэлт өгч, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөмж өгдөг байна.

2.33. БНХАУ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо 5 жилээр тасалбар болгон боловсруулж, Ардын Их Хурлаар батлуулдаг бөгөөд ҮАГ нь 2016 оноос эхлэн “Бодит цагийн аудит”-ын горимыг ашиглан аудит хийж эхэлсэн байна.

2.34. Дээрх 2 улсын үндсэн чиглэлийн биелэлтэд хэрхэн аудит хийдгийг Монгол Улсын ҮАГ-тай харьцуулан харуулбал:

Шигтгээ 1. Үндсэн чиглэлийн аудитыг гүйцэтгэх олон улсын туршлага

Аудитын дээд байгууллага	Монгол Улсын Үндэсний аудитын газар	Австрали Улсын Үндэсний аудитын газар ²³	БНХАУ-ын Үндэсний аудитын газар ²⁴
Аудитын төрөл	Гүйцэтгэлийн аудит	Гүйцэтгэлийн аудит	Нийцлийн аудит
Үнэлгээ	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, хавсралт журмын дагуу тоон үзүүлэлтээр биелэлтийг үнэлдэг.	Хөндлөнгийн үнэлгээ, зөвлөх хэлбэртэй. Аудитын стандартын дагуу гол дутагдлуудыг учир шалтгааныг тодруулж үнэлдэг.	Тоон үзүүлэлтээр үнэлдэггүй. Зорилт арга хэмжээ хэрэгжихтэй аудитын шалгалт зэрэгцдэг тул бодит байдлыг үнэлдэг.
Аудитыг хэрэгжүүлэх зарчим	Зорилт арга хэмжээний хэрэгжилт тус бүрийг нотлох баримтад үндэслэдэг. Аудитын илрүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтийг сайжруулах дүгнэлт, зөвлөмж өгдөг.	Бодлогын хэрэгжилтийг сайжруулахад холбогдох мэргэжлийн боловсон хүчний оролцоог тодорхойлж, мэдлэг туршлагыг нэмэгдүүлэхийг зорьдог.	Бодлогын хэрэгжилтийн сул талыг засах, хэрэгжилтийг сайжруулахад анхаардаг. Хэрэгжилтийн явцад илэрсэн дутагдлыг зөвлөмж өгч залруулдаг.
Тайлагнал	Монгол Улсын Их Хуралд тайлагнадаг.	Австрали Улсын Парламентад тайлагнадаг.	Бүх Хятадын Ардын Их Хуралд тайлагнадаг.

2.35. ҮАГ-аас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр гүйцэтгэлийн аудит хийж байгаа боловч цаг хугацааны хувьд хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, ЗГХЭГ-аас үндсэн чиглэлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлж байх хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.

²³Эх сурвалж: by Public Governance, Performance and Accountability Act 2013 /ANAO/, <https://onlinelibrary.wiley.com/doi/pdf/10.1111/j.1468-0408.2007.00431.x>
<https://www.anao.gov.au/pubs/>

²⁴Real-time Audit Results of the Implementation of Major National Policies and Measures in the 3rd Quarter of 2016



Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 136 зорилт, арга хэмжээ батлагдсанаас агуулгын хувьд давхардсан тоогоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-аас 97, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 124, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрөөс 19, үндэсний болон төрөөс баримтлах салбарын бусад бодлогын баримт бичгээс 17 арга хэмжээ тус тус тусгагдсан байна.
- Үндсэн чиглэлд батлагдсан зарим зорилт арга хэмжээ нь урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, ЗГҮАХ, төрөөс тухайн салбарт баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн зарим зорилттой уялдахгүй байна.
- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцсан байгууллагын чиг үүрэг нь эрх зүйн орчны хувьд давхардалтай байна.
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн нөхцөл байдлын болон нийгэм эдийн засгийн үр ашиг, үр нөлөөний судалгаа, дүн шинжилгээ, тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, санхүүжилтийн эх үүсвэртэй бүрэн уялдуулахгүй байна.
- Үндсэн чиглэлд бэлтгэл ажил хангагдаагүй, зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг оновчтой, хэрэгжих боломжтой байхаар төлөвлөөгүйгээс шалтгаалан эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын зарим зорилт, арга хэмжээ биелээгүй байна.
- Үндсэн чиглэлд бодлогын хувьд давхардсан олон хөтөлбөрийг зохион байгуулахаар төлөвлөж, хэрэгжүүлэхээр байгаа нь тухайн бодлогын хэрэгжилт хангалтгүй байх, хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.
- Үндсэн чиглэлд зарим арга хэмжээ ижил агуулгатай батлагдсанаас тайлагнал давхардсан, биелэлтийг нэгтгэн дүгнэхдээ үр нөлөө, үр дагаврыг бодитой тооцож үнэлээгүй, өөр арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан тохиолдол гарч байна.
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, Сангийн яам, ЗГХЭГ-ын Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, тайлагнах үйл ажиллагаанд ахиц гараагүй байна.
- ҮАГ-аас үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр гүйцэтгэлийн аудит хийж байгаа боловч цаг хугацааны хувьд хариуцан хэрэгжүүлэгч байгууллага, ЗГХЭГ-аас үндсэн чиглэлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлж байх хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлан илгээх, хүлээн авах мэдээллийн урсгалыг удирдахад Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг бүрэн ашиглахгүй байна.



Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэж, шийдвэр гаргахдаа хууль тогтоомжийн дагуу нөхцөл байдлын судалгаа хийгдсэн, санхүүжилтийн эх үүсвэрийг нь бүрэн тооцсон зорилт, арга хэмжээг баталж байх;
- Монгол Улсын Засгийн газар жил бүр үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг УИХ-д хүргүүлсний дараа аудитын дүгнэлт гаргуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцсан байгууллагын чиг үүрэг хариуцлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон давхардлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, нэгтгэн боловсруулах, хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалт болон хамтран хэрэгжүүлэгч яам, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, ажлын хариуцлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлан илгээх, хүлээн авах мэдээллийн урсгалыг удирдахад Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн ашиглалтыг сайжруулах;
- Үндсэн чиглэлийн биелэлт, хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг төрийн аудитын байгууллагад хагас, бүтэн жилээр ирүүлж байх асуудлыг судалж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудад үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн аудитын тайланг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Сангийн сайдад:

- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад салбарын яам, хариуцан хэрэгжүүлэгч байгууллагатай хийх зөвшилцөл, хэлэлцүүлгийг баримтжуулах, тэргүүлэх ач холбогдол бүхий тодорхой үр дүнд чиглэсэн зорилт, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөж, нэгтгэн тайлагнахад анхаарах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журмын дагуу нөхцөл байдлын шинжилгээ, тооцоо судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, санхүүжилтийн эх үүсвэр, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой хэрэгжих, үнэлэх боломжтойгоор боловсруулж байх;
- Үндсэн чиглэлийн биелэлтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлттэй нь уялдуулж, үр дагаврыг үнэлж, тухайн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр бодитой тайлагнах.



Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ¹⁹он ⁰⁴дугаар
сарын ¹⁸-ны өдөр

Дугаар ^{ХЭГ}
¹¹⁰³¹

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох тайлбарыг хүргүүлж байна.

Тайлбарт дурдсан мэдээллийг харгалзан үзэж Үндсэн чиглэлд заасан зарим арга хэмжээний гүйцэтгэлийг дахин хянан үзэх арга хэмжээ авна уу.

Хавсралт: 4. хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0004521



**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн
чиглэлийн хэрэгжээгүй гэсэн саналтай зорилт,
арга хэмжээний талаарх тайлбар**

**1.12. Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг
бууруулах хөтөлбөр боловсруулах**

Тайлбар
1-ийг
үзнэ үү.

Тайлбар: Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар ажлын хэсэг байгуулагдан “Монгол Улсын гадаад өрийн хэмжээг бууруулах стратеги”-ийн саналыг 2018 оны нэгдүгээр улиралд багтаан боловсруулж, Монголбанкны удирдлагад танилцуулсан бөгөөд, өнөөдрийн байдлаар холбогдох газруудад санал авахаар хүргүүлсэн байна.

Сангийн сайд болон Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан А-19 тоот тушаалаар “Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөний төслийг боловсруулах” **ажлын хэсэг** байгуулагдан ажилласан. Үүний дагуу улсын хэмжээнд төлөгдөх гадаад өрийн үйлчилгээний төлбөрийн хуваарийг өдөр, сараар бэлтгэн, түүнд үндэслэн гадаад валютын шаардлагатай эх үүсвэрийг өдрөөр бэлтгэж, cross-default үүсгэж болзошгүй гадаад өр, улсын төсвөөс төлөгдөж болзошгүй эрсдэлийг судласан. Ажлын хэсгээс гарсан үр дүнг үндэслэн 2017-2018 онд төлөгдөх хуваарьтай Чингис, ДимСам, Хөгжлийн банкны евро бондуудын төлбөрийг Гэрэгэ, Хуралдай бондыг арилжаалан дахин санхүүжүүлж өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Засгийн газар 2018 онд үндсэн төлбөр 2.6 их наяд, хүүгийн төлбөр 1.2 их наяд төгрөг буюу нийт 3.8 их наяд төгрөг төлөх шаардлагатай байгаагаас 6-р дугаар сард хамгийн өндөр ачаалалтай буюу **753.3 тэрбум** төгрөгийн гадаад, дотоод өрийг хуваарийн дагуу төлж барагдуулав. Засгийн газар дээрх өрийг төлөхдөө төсөв, санхүүгийн үр ашигтай, оновчтой удирдлагыг хэрэгжүүлж арилжааны нөхцөлтэй өндөр хүүтэй өр, зээл тавихгүйгээр амжилттай шийдлээ. Ийнхүү 2017 оны эцэст 22.7 их наяд төгрөг байсан Монгол Улсын Засгийн газрын өр 2018 оны урьдчилсан **гүйцэтгэлээр 22.4 их наяд төгрөг болж буурлаа.**

	2017	2018	2019*	2020*
ГАДААД БОНД	1,359.4	1,168.0	513.9	560.9
Үндсэн төлбөр	950.8	645.4	0.0	0.0
Хүүгийн төлбөр	408.5	522.5	513.9	560.9
ГАДААД ЗЭЭЛ	278.6	451.5	993.7	647.3
Үндсэн төлбөр	165.2	280.2	851.8	453.4
Хүүгийн төлбөр	113.4	171.3	141.9	194.0
ГЭРЭЭНД ЗААСАН ШИМТГЭЛ	25.8	0.6	0.0	0.0
ГЭРЭЭНД ЗААСАН ШИМТГЭЛ	25.8	0.6	0.0	0.0
НИЙТ	1,663.8	1,620.0	1,507.6	1,208.3

Тайлбар: *төлөвлөгөө



Тайлбар
1-ийг
үзнэ үү.

1.13. “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх

Тайлбар: УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн 1.1.2 дахь хэсэгт заасны дагуу “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр”-ийг боловсруулж, 2017 оны төсвийн жилд төрийн байгууллагуудын зардлыг бууруулах, хэмнэлт бий болгох чиглэлээр нийт 13 арга хэмжээг “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд тусган боловсруулж яамдаас санал авч ЗГХЭГ-т 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 4-3/4784 тоотой хүргүүлсэн ба Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.

Тус хөтөлбөрийн төсөлд тусгагдсан зарчмыг баримтлан дунд хугацаанд төрийн байгууллагуудын зарлага нэмэгдэх ачааллыг бууруулж, хэмнэлт бий болгохоор 2017 оны төсөв, УИХ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан 2017 оны төсвийн тодотгол болон УИХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан 2018 оны төсөвт тус тус тусгасан болно.

Тухайлбал, “Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр”-ийн төслийн 3.1-д заасан бараа үйлчилгээний зардлын хэмнэлтийн 13 арга хэмжээг баримтлан төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн 2018 оны төсвийн саналыг 455 тэрбум төгрөгөөр бууруулж УИХ-д өргөн мэдүүлж, батлуулсан.

2.3. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх;

Тайлбар
2-ыг
үзнэ үү.

Тайлбар: Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “2015-2030 оны аймгийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 05 дугаар тогтоолд Цэцэрлэг сумын нутагт 87.0 га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээнд авч аймаг дундын отрын бүс нутаг байгуулахаар орсон. Энэ тогтоолыг үндэслэж ХХААХҮ-ийн сайд улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг байгуулах зорилгоор бэлчээрийн даац тодорхойлох, хилийн цэсийг тогтоох, ургамлын төрөл зүйлийн судалгаа хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд 2 удаа ажиллаж улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг байгуулахын ач холбогдол, аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үйл ажиллагааг танилцуулж, ургамлын төрөл зүйлийн судалгааг хийсэн. Газрыг улсын тусгай хэрэгцээнд газар авах журмаар багийн ИНХурлын тогтоол, сум, аймгийн ИТХ-ын тогтоол, сум, аймгийн Засаг даргын захирамж тус тус гарснаар ХХААХҮЯам болон БХБЯам улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг байгуулах асуудлыг боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулж тогтоол гаргуулах ёстой. Цэцэрлэг сумын Зуун мод багийн иргэдийн Нийтийн Хурлын 2018.05.10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор аймаг дундын отрын бүс нутаг байгуулах асуудлыг дэмжсэн. Харин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018.11.01-ны өдрийн 08 дугаар тогтоолоор аймаг дундын отрын бүс нутаг байгуулах асуудлыг дэмжээгүй. Ажлын хэсэг 2 жилийн хугацаанд аймаг дундын отрын бүс нутаг байгуулах ажлыг дэмжсэн



тогтоол гаргуулахаар сумын удирдлагуудтай удаа дараа уулзаж ач холбогдлыг танилцуулж ажилласан боловч Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дэмжээгүй.

3.5. Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Тайлбар
3-ыг
үзнэ үү.

Тайлбар: "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн боловсруулж, яамдаас ирсэн санал болон 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн гишүүдийн саналыг тусган боловсруулав. "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийн төсөл боловсруулан яамдаас санал авч тусган, Сангийн яамнаас зөвшөөрөл авч, 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулсан бөгөөд хөтөлбөр батлагдсаны дараа ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлан хэрэгжүүлэх болно.

2018 онд жижиг, дунд үйлдвэрийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЖДҮХС-гийн хөрөнгийг улсын төсвийн санхүүжилтээр 70.4 тэрбум төгрөгөөр, Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгийг АХБ-ны санхүүжилт 10.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бол арилжааны банкнаас ЖДҮ эрхлэгчдэд олгох зээлийн хэмжээг ЕСБХөгжлийн банкны санхүүжилт 86.5 сая америк долларын хөрөнгөөр нэмэгдүүлсэн. Ингэснээр 2018 онд ЖДҮХС-гаас 212 төсөлд 96.4 тэрбум төгрөг, сум хөгжүүлэх сангаас 197 аж ахуйн нэгжид 3.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл шууд олгож, нийт 409 аж ахуйн нэгжид 99.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 1450 шинэ ажлын байр бий болж, 1489 ажлын байр хадгалагдсан байна.

4.5. Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих

Тайлбар
4-ийг
үзнэ үү.

Тайлбар: "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл"-ийн хүрээнд 2018 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нэгж" хийж гүйцэтгэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2018 оны 8 дугаар сарын 14-ны өдөр хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гаргасан. Төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэн 2018 оны 5 дугаар сарын 20-нд хүлээн авсан бөгөөд уг тайланг Байгаль орчин аялал жуулчлалын яам хянан үзэж 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 13/8361 дугаартай албан бичгээр дүгнэлт гаргаж ирүүлсэн. Үйлдвэр барих зорилгоор **Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг** үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" тогтоолын төслийг боловсруулж БХБЯ-аас холбогдох саналыг авч, 2018 дугаар 12 сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар уг асуудлыг

хэлэлцэн, дэмжсэн. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 08 дугаар сараас 10 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Уг төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг "Өмгөөллийн Монгол өмгөөлөгч" ХХН-тэй байгуулсан бөгөөд явцын тайланг хүлээн аваад байна.



Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар

Тайлангийн төсөлд ирүүлсэн 5 санал ирснээс 2 саналыг хүлээн авч 3 саналыг хүлээн авах боломжгүй байна. Доорх тайлбарыг үзнэ үү.

Тайлбар 1. Саналыг хүлээн авч тайланд засвар хийсэн болно.

Тайлбар 2. Орон нутгийн түвшинд асуудал шийдвэрлэгдээгүй, зорилтот түвшинд хүрээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 3. Хөтөлбөрийн төсөлд яамдаас санал авч тусган 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэснийг цаг хугацаандаа хэрэгжээгүй, саналын ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон санхүүжилт, хамрагдсан аж нэгжийн талаарх тайлбар нь үндсэн чиглэлийн 3.4-т туссан арга хэмжээнд тайлагнагдсан тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар 4. Байршил өөрчлөөгүй нэршлээр үндсэн чиглэлд тусгагдсан, мөн зорилт, арга хэмжээний 4.4-ийн үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах дэд арга хэмжээтэй давхацсан, хэрэгжээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.



Үндсэн чиглэлийн дутуу хэрэгжсэн зорилт, арга хэмжээний жагсаалт

№	д/д	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Хариуцах байгууллага
1	1.3	Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах мөнгөний бодлого хэрэгжүүлэх	70.0	МБ
2	1.7	Банк, санхүүгийн салбарыг хямралд хүргэж болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлох	40.0	МБ
3	1.8	Банкны системийн зээлийн эрсдэлд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр иргэдийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах	70.0	МБ
4	1.9	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх	70.0	ХНХЯ
5	1.10	Бизнес эрхлэлтийн санхүүгийн зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх	40.0	МБ
6	1.11	Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох	40.0	СЗХ
7	1.12	Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулах хөтөлбөр боловсруулах	40.0	СЯ
8	1.13	“Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх	40.0	СЯ
9	2.5	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах	70.0	ХХААХҮЯ
10	3.1	Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	70.0	ХХААХҮЯ
11	3.2	“Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах	40.0	ХХААХҮЯ
12	3.3	Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх “Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	70.0	ХХААХҮЯ
13	3.4	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих	70.0	ХХААХҮЯ
14	3.7	Төрөөс худалдан авах дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх	70.0	ХХААХҮЯ
15	3.8	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдан авалтын бодлогыг батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдал, цагдаагийн болон бусад төрийн байгууллагад тууштай хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	70.0	ТӨБЗГ
16	4.1	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	40.0	УУХҮЯ
17	4.3	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	40.0	УУХҮЯ
18	4.4	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	40.0	УУХҮЯ
19	5.1	Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	40.0	ЭХЯ



20	5.3	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	40.0	ЭХЯ
21	5.4	Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлэх	40.0	ЭХЯ
22	5.6	Хот, суурин газрын цахилгаан түгээх сүлжээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	70.0	ЭХЯ
23	5.7	Багануурын ДЦС-ыг барих ажлыг үргэлжлүүлэх	70.0	ЭХЯ
24	6.1	Зам, тээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	40.0	ЗТХЯ
25	6.4	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	0.0	ЗТХЯ
26	6.5	Худалдааг хөнгөвчлөх тээвэр, логистикийн төв байгуулах ажлыг үргэлжлүүлэх	40.0	ЗТХЯ
27	6.6	Иргэний нисэхийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	40.0	ЗТХЯ
28	7.1	Хүн амын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	40.0	БХБЯ
29	7.2	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах	40.0	БХБЯ
30	7.3	Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	40.0	БХБЯ
31	7.4	Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	40.0	БХБЯ
32	7.5	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд инженерийн дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэх	70.0	БХБЯ
33	7.6	Ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх	70.0	БХБЯ
34	8.1	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	70.0	БОАЖЯ
35	8.2	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	40.0	БОАЖЯ
36	8.3	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтыг сайжруулах	40.0	БОАЖЯ
37	8.6	Цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах хүрээнд "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр", "Ногоон хэрэм", "Ногоон хөгжлийн бодлого" баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	70.0	БОАЖЯ
38	8.7	Аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах	40.0	БОАЖЯ
39	8.8	Аялал жуулчлалын бүс нутагт түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв цогцолбор байгуулах	40.0	БОАЖЯ
40	9.2	Онцгой байдлын албаны аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлж, гал түймрийн шалтгааныг шуурхай тодорхойлох галын лабораторийн чадавхыг бэхжүүлэх	70.0	ОБЕГ
41	10.2	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн ая тухтай сурч, боловсрох орчин, нөхцөлийг бүрдүүлэх	40.0	БСШУСЯ
42	10.3	Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	70.0	БСШУСЯ



43	10.8	Сурагчдыг эх хэлээрээ алдаагүй, зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтын цогц шинэчлэлийг хэрэгжүүлэх	70.0	БСШУСЯ
44	12.1	Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх	40.0	БСШУСЯ
45	12.2	Инновацийг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх	70.0	БСШУСЯ
46	12.5	Мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлийн энтэрпренёр бэлтгэх	70.0	ХХМТГ
47	12.6	Төрийн байгууллагуудад цахим албан хэрэг солилцооны нэгдсэн мэдээллийн системийг нэвтрүүлэх	70.0	ХХМТГ
48	13.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг өргөтгөх, байгууллагын чадавхыг сайжруулах	40.0	ЭМЯ
49	13.2	Зонхилон тохиолдох халдварт өвчний оношилгоо эмчилгээний чадавхыг сайжруулах	70.0	ЭМЯ
50	13.3	Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эндэгдлийг бууруулах	40.0	ЭМЯ
51	13.4	Нотолгоонд суурилсан эм зүйн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх	70.0	ЭМЯ
52	13.5	Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах	70.0	ЭМЯ
53	13.6	Иргэн бүрийг жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах бодлогыг үе шаттай хэрэгжүүлж эхлүүлэх	70.0	ЭМЯ
54	13.7	Осол гэмтэл, түлэнхийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх	70.0	ЭМЯ
55	14.1	Гэр бүл, өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжиж, нийгмийн хамгааллын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	70.0	ХНХЯ
56	14.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх	70.0	ХНХЯ
57	14.5	Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх	70.0	ХНХЯ
58	14.6	Мэргэжлийн боловсрол, сургалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	70.0	ХНХЯ
59	14.8	Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих	70.0	ХНХЯ
60	14.9	Их, дээд сургууль, МСҮТ төгсөгчдөд өөрт бий болгосон ур чадвартаа түшиглэн ажлын байр, орлоготой болох гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмж лизингээр олгох хөтөлбөр хэрэгжүүлэх	70.0	ХНХЯ
61	14.10	Эрүүл мэндийн даатгалын бие даасан, даатгуулагч төвтэй, орчин үеийн менежменттэй тогтолцоог бий болгох, эрүүл мэндийн даатгалын иргэдэд хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	70.0	ЭМЯ
62	14.12	Ахмад настны тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч ажиллах	70.0	ХНХЯ
63	15.1	Архивын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, төрийн архивуудад хадгалагдаж байгаа баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх	70.0	ХЗДХЯ



64	15.2	Гэрч, хохирогчийг хамгаалах, нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	70.0	ХЗДХЯ
65	15.3	Шүүхээр шийдвэрлүүлж байгаа хэрэг, маргаан болон хүн амын төвлөрлийг харгалзан шийдвэр гүйцэтгэх чадавхыг бэхжүүлэх	40.0	ХЗДХЯ
66	15.5	Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	70.0	ХЗДХЯ
67	15.8	Хилийн заставын цахилгаан, дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шинэчлэх	70.0	ХЗДХЯ
68	15.11	Орчин үеийн эрүүл ахуйн стандартад нийцсэн Шүүх эмнэлгийн байрыг шинээр байгуулах	40.0	ХЗДХЯ
69	16.3	"Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих", "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	70.0	ШӨХТГ
70	16.6	Төрийн аудитын стандартыг боловсруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	40.0	ҮАГ
71	17.1	Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	70.0	ГХЯ
72	17.2	Монголын бараа, бүтээгдэхүүнийг таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон хязгаарлалтыг бууруулах	70.0	ГХЯ
73	17.4	Хилийн чанад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	70.0	ГХЯ
74	18.2	Монгол Улсын агаарын хил, орон зайн хяналтын системийг сайжруулж, онц чухал объект, цэргийн бүлэглэлийг агаараас халхлах боломжийг нэмэгдүүлэх	70.0	БХЯ

Хавсралт 2

Үндсэн чиглэлийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний жагсаалт

№	д/д	Бодлогын, зорилт арга хэмжээ	Хэрэгжүүлэгч байгууллага
1	2.3	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх	ХХААХҮЯ
2	3.5	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх	
3	4.5	Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих	УУХҮЯ
4	5.2	Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станцын барилгын ажлын явц	ЭХЯ
5	5.5	Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлыг үргэлжлүүлэх	
6	6.4	Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	ЗТХЯ
7	6.7	Говь-Алтай-Баянхонгор-Улаанбаатарын баруун чиглэлийн хатуу хучилттай авто замын "Хүйтний хөндий" дэх засварын ажлыг гүйцэтгэх	
8	10.10	Зарим их, дээд сургуулийг Дархан-Уул, Орхон, Багануур, Сэлэнгэ аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлэх	БСШУСЯ
9	11.3	Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг төрөөс дэмжлэг үзүүлэх	

